



**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН
ХОЛБОО**

**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2018 он

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ . ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Товч танилцуулга
- 1.2 Бүтэц, зохион байгуулалт, орон тоо, хөрөнгийн байдал

ХОЁР. ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

- 2.1 Даатгалын сан бүрдүүлэх нөхөн төлбөр олгох, буцааж төлүүлэх талаар
- 2.2 Мэдээллийн сан үүсгэж, холбооны гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах мэдээлэл солилцох талаар
- 2.3 Даатгалын тохиолдлыг үнэн зөв тодорхойлж үйлчилгээ үзүүлэх Шуурхай албаны талаар
- 2.4 Албан журмын даатгалыг хэрэгжүүлэх, даатгалын тухай хуулийн мэдээлэл, мэдлэгийг олон нийтэд олгох, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны талаар

ГУРАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- 3.1 Санхүүгийн тайлан үр дүнгийн талаар
- 3.2 Орон нутгийн салбарын үйл ажиллагаа, үр дүн
- 3.3 Дотоод хяналт, салбар, нэгжийн ажил дүгнэсэн тухай

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ



ХОЛБООНЫ ТУХАЙ

АЛСЫН ХАРАА:

Монгол Улсын даатгалын салбарын хөгжил дэвшлийн тулгуур болсон, олон улсын жишигт хүрсэн хариуцлагын албан журмын даатгалын байгууллага байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Жолоочийн даатгалын хуулийн хэрэгжилтийг хангаж, хариуцлагын даатгалын нөхөн төлбөрийн найдвартай нөөц бүрдүүлж, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэхэд оршино.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС:

АЖДХолбооны хамт олны гишүүн бүр дараах үнэт зүйлсийг эрхэмлэн дагаж мөрдөнө. Үүнд:

- Даатгагч болон даатгуулагч
- Харилцагчид
- Мэргэжлийн өндөр ёс суртахуун бүхий ажилчид
- Сайн засаглал
- Хамт олон
- Уламжлал ба шинэчлэл

УРИА:

Хариуцлагын даатгал таныг хамгаална.

ХОЛБОО БАРИХ:

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Чингисийн өргөн чөлөө 17,
Гэрэгэ тауэр, 12-р давхар
Албан журмын даатгагчдын холбоо
Утас: 70121177, 70001040
Факс: 70001040

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:


1.1 Товч танилцуулга

Улсын их хурлаас 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Жолоочийн даатгалын тухай хуулийг баталж, Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Санхүүгийн зохицуулах хороо 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 301 дугаар тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилж мөн оны 11 сарын 07-ны өдөр Холбооны дүрэм батлагдаж, улсын бүртгэлд №9072004107 дугаарт бүртгүүлснээр Албан журмын даатгагчдын холбоо (ТББ) үүсч байгуулагдсан байна.

Тус холбоо нь Даатгалын санг бүрдүүлж, нөхөн төлбөр олгох, буцаан нэхэмжлэх, даатгалын сангийн шуурхай албыг зохион байгуулах, жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хяналт тавих, албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчдын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах жолоочийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, зам тээврийн ослыг бууруулахад, чиглэсэн сургалт, сурталчилгааг санхүүжүүлэх үүрэгтэй хуулийн этгээд юм.

Санхүүгийн зохицуулах хороон зөвшөөрч, Удирдах зөвлөлөөс баталсан дүрмийн дагуу АЖДХолбооны үйл ажиллагаа явагдаж байна. Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлд Албан журмын даатгагчдын холбооны эрх, үүргийг тодорхойлж өгсөн байгаа юм. Мөн жолоочийн даатгалын тухай хуульд Холбооны жолоочийн даатгалын сангийн эх үүсвэр, түүнийг зарцуулах зориулалтыг зааж өгчээ.

АЖДХолбооны Удирдах зөвлөлийн 2016 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан бүтэц, зохион байгуулалтын бүдүүвчийг харуулбал:



Албан журмын даатгагчдын холбооны 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор орон нутаг дахь салбаруудыг бүсчлэн зохион байгуулсан газар зүйн зураг.



Эндээс харахад Холбооны үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болох боловч цаашид боловсронгуй болгох ажил их байгаа учраас хойно санал дэвшүүлж байна.

2017 онд Холбооны Удирдах зөвлөл нийт 8 удаагийн хуралдаан хийж, 22 тогтоол гаргаж, “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийн шинэчилсэн найруулгыг батлах тухай, Орон нутаг дахь салбаруудыг бүсчлэн зохион байгуулсантай холбогдуулан “Салбарын ажиллах журам” болон Орон тооны зарим зохицуулалт хийж, ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулах тухай, “Албан журмын даатгагчдын холбооны Хяналтын зөвлөлийн ажиллах журам”, Албан журмын даатгагчдын холбоо (ГҮТББ)-ны орлого, Жолоочийн Даатгалын санг 2018 онд бүрдүүлэх, зарцуулах хэмжээг батлах тухай, Албан журмын даатгагчдын холбооны 2018 оны төсвийн тухай, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай тогтоолуудыг тус тус хэлэлцэж батлуулсан байна.


Даатгалын тухай хуулийн 12¹,6-д заасан эх үүсвэрээр холбооны хөрөнгийг, Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1-д заасан эх үүсвэрээр жолоочийн даатгалын санг бүрдүүлж, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасан зориулалтаар зарцуулж, зарцуулалтын тайланг гаргаж байна. Даатгалын сан, холбооны 2016, 2017 оны хөрөнгийн байдлыг (хүснэгт №1-ээр) харуулбал:

Хүснэгт №1 /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн нэр	2016 оны жилийн эцсийн байдлаар	2017 оны жилийн эцсийн байдлаар
1	Мөнгөн хөрөнгө	70,134	2,659,474
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /хадгаламж/	6,954,868	9,968,301
3	Авлага	2,209,143	171,269
4	Эргэлтийн хөрөнгө	9 255,388	12,805,902
5	Үндсэн хөрөнгө	528,502	398,182
6	Биет бус хөрөнгө	191,503	458,226

Даатгалын сан, холбооны 2016, 2017 оны хөрөнгийн байдлыг харуулбал:

График №1



Даатгалын тухай хуулийн 12¹.1-д албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Холбооны гишүүн байна гэж заасан байдаг. Холбооны хөрөнгө гишүүдийн элсэлт, тухайн жилийн татвараас үндсэндээ бүрдэж байгаа бөгөөд Удирдах зөвлөлөөс баталсан зориулалтын дагуу зарцуулж байна. Албан журмын даатгагчдын Холбоо 2016 онд 59 орон тоотой 735,0 сая төгрөгийн цалингийн сантайгаар ажиллаж байсан бол 2017 онд 25 орон тоотой 496,8 сая төгрөгийн цалингийн сантай ажиллаж үндсэн үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүллээ.

2017 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн дотоод журмын дагуу гүйцэтгэх захирал нийт 95 тушаал гаргаснаас нөхөн төлбөртэй холбоотой асуудлаар 31, ажилд томилох 14, хөдөлмөрийн гэрээ цуцалсан 14, жирэмсний амралт олгосон 2, сахилгын шийтгэл ногдуулсан 3, чөлөө буцалтгүй тусламж 6, шагнал урамшуулал 4, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 25 тушаал гарчээ.

Холбооны нийт бичиг хэргийн эргэлт 864 , үүнээс албан байгууллага иргэдээс 390, өргөдөл гомдол 63-ийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж албан байгууллага, иргэдэд нийт 474 албан бичиг явуулсан байна.

Холбоо нь Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар, даатгалын мэргэжлийн оролцогчидтой хамтран ажиллаж дараах үр дүнд хүрсэн байна.

ХОЁР. ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

2.1 ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ, ХОХИРОГЧИД НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛЖ БУЙ ДААТГАЛЫН САНГИЙН ТАЛААР:

Монгол улсын Их хурлаас 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан “Жолоочийн даатгалын тухай хууль”- ийн тавдугаар бүлгийн 22.1-д Жолоочийн даатгалын санг үндсэн 6 төрлийн эх үүсвэрээр бүрдүүлэхээр заасан. Холбоо нь хуулийн дагуу даатгалын сангийн орлого төвлөрүүлэх ажлыг зохион байгуулдаг.

2.1.1 Даатгалын сангийн бүрдүүлэлтийн талаар

Холбооны 2017 оны орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд ихээхэн анхаарч Нийслэл болон 21 аймгийн засаг даргын тамгын газар, тамгын газрын Санхүү төрийн сангийн эрх бүхий хүмүүстэй тогтмол холбоотой байж Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийг аймаг, нийслэлийн санхүү төрийн сангаас гаргаж өгсөн хуваарь болон АТБӨЯХАТ-ын гүйцэтгэлтэй уялдуулж санд төвлөрүүлэх ажлыг жилийн турш зохион байгуулж ажиллаа. Жолоочийн даатгалын санд 4,225,481,2 мянган төгрөг төвлөрүүлэх зорилт тавьж 4,928,672,8 мянган төгрөг төвлөрүүлж 16% буюу 703,191,6 мянган төгрөгөөр давуулж биелүүллээ. /Хүснэгт № 2/

2017 онд Нийслэл болон зарим аймгаас ЖДСанд 2015,2016 онд төвлөрүүлэх АТБӨЯХАТ-ын гүйцэтгэлийн зөрүүдээс үүссэн болон бусад авлага 2,037,8 сая төгрөг төвлөрүүлж барагдууллаа.

Түүнчлэн Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.1-д заасан Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгагч бүрээс 2017 онд Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалын дагуу Даатгагч бүрийн

2016 оны Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлогод тооцсон хураамжаас 1,8 хувиар тооцон санд бүрэн төвлөрүүлээ. “Мөнх даатгал” ХХК нь тус онд Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх 10,296,931.0 төгрөгөөс Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлогод тооцсон хураамжаа буруу тооцоолсон гэх шалтгаанаар 1,277,025 төгрөг санд төвлөрүүлснийг Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын газар, Хяналт шалгалтын газруудаас шалгаж нөхөн төлүүлсэн болно.

Даатгалын сангийн 2017 онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт №2 /мянган төгрөгөөр/

№	Орлогын төрөл	2016 оны төлөвлөгөө	2016 оны гүйцэтгэл	2017 оны төлөвлөгөө	2017 оны гүйцэтгэл	Биелэлт хувь
1	Авто тээврийн болон өрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь /АТБӨЯХАТ/	3 284 470,50	2 033 381,1	3,042,481.2	3,497,267.96	114%
2	Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчдаас төвлөрүүлэх хөрөнгө	450 000,0	390 133,0	400,000.0	444,625.1	111%
3	Жолоочийн даатгалын хууль тогтоомжийн зөрчилд ногдуулсан торгуулийн орлого	5 000,0	480,0	3,000.0		0%
4	Мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого	30 000,0	34 989,2	30,000.0	50,699.9	168%
5	Хүүгийн орлого	717 024,0	518 692,4	650,000.0	833,540.6	125%
6	Нөхөн төлбөрийн буцаан төлөлт	100 000,0	100 919,3	100,000.0	102,539.2	102%
	Нийт дүн	4 586 497,5	3 078 595,0	4,225,481.2	4,928,672.8	116%

2017 онд жолоочийн даатгалын санд нийт 4,928,672,8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 16 хувиар буюу 703,191,6 мөнгөн төгрөгөөр давуулан биелүүлсэн болно.

2.1.2 Даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд замын хөдөлгөөнд оролцохдоо бусдад учруулсан хохирлыг арилгахаар Даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн талаар:

Албан журмын даатгагчдын холбооны Даатгалын санд 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс 2017 оны 12 сарын 27-ны өдрийн хооронд иргэд, аж ахуй нэгжээс 37 өргөдөл бичиг хэрэгт шинээр бүртгэгдсэн ба өмнөх оны 6 өргөдөл ба нийт 42 өргөдлийн 117.912.565 төгрөгийн нөхөн төлбөртэй холбоотой бичиг баримтыг судалж хохирогч болон буруутай этгээд, зохих заавар, журмын дагуу материал бүрдүүлэлтийг хангуулж, буруутай этгээдтэй гэрээ байгуулан, хохирогчид нөхөн төлбөр олгох бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн байна.

Нөхөн төлбөр хүссэн өргөдөл шийдвэрлэлт

Хүснэгт №3

Д/д	Шийдвэрлэлтийн байдал	2017 он	2016 оноос шилжсэн	нийт
1	Хүлээн авсан өргөдлийн тоо	40	2	42
2	-Жолоочийн даатгалын сангаас олгосон	29	1	30
3	-Олгохоос татгалзсан	9	0	9
4	-Буруутай тал нь бэлнээр барагдуулсан	1	0	1
5	Хянагдаж, материал бүрдүүлэлтийн шатанд	1	1	2

Нөхөн төлбөр хүссэн өргөдлийг дээрх байдлаар шийдвэрлэж ажиллахдаа Жолоочийн даатгалын тухай хуулийн 13.2,13.6 дахь заалтууд, Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар зэргийг баримтлан ажилласнаас гадна нөхөн төлбөр авах шаардлага хангасан этгээдүүд болон батлан даагч нарын оршин суугаа хаягийг нэг бүрчлэн шалган баталгаажуулж ажиллалаа.

Ирүүлсэн өргөдлийг бүтцээр нь авч үзвэл


График №2



Жолоочийн даатгалын сангаас тайлангийн хугацаанд хохирогчид олгосон нийт нөхөн төлбөрийн 83.3% буюу 105,391,965 төгрөгийн нөхөн төлбөрийг ЖДТХ-ийн 18.1.1-дэх заалт, 11.9% буюу 6,764,600 төгрөгийн нөхөн төлбөрийг ЖДТХ-ийн 18.1.2-дахь заалт, 4,7 % буюу 5,756,000 төгрөгийн нөхөн төлбөрийг ЖДТХ-ийн 18.1.5-дахь заалтуудыг тус тус үндэслэн даатгалын тохиолдлын хохирогчид олгосон болно.

Нөхөн төлбөр нэхэмжилсэн 42 өргөдлийг ЖДТХуулийн 18 дугаар зүйлийн “ЖДСангаас нөхөн төлбөр олгох” заалтын дагуу задалж харуулбал:

График №3



18.1.1 буюу даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан 35 өргөдөл нь нийт нөхөн төлбөр нэхэмжилсэн өргөдлийн 83,3% хувийг, 18.1.2 буюу даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргаж 5 өргөдлөөр нөхөн төлбөр нэхэмжилсэн нь 11,9 %-ийг тус тус эзэлж байна. 18.1.3 буюу бусдын амь нас эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус, 18.1.4 буюу даатгагч дампуурсан заалтуудыг дурдаж нөхөн төлбөр нэхэмжлээгүй байна. 18.1.5 буюу бусад үндэслэлээр 2 өргөдлийг шийдвэрлэжээ.

Жолоочийн даатгалын сангаас Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийг үндэслэн даатгалын тохиолдлын хохирогчид 74,533.7 мянган төгрөгийн нөхөн төлбөр олгож, буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх гэрээ байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласнаар 102,839.2 мянган төгрөгийг санд буцаан төвлөрүүлэв. 2013 оноос хойш, Жолоочийн даатгалын сангаас нийт 226 даатгалын тохиолдлын хохирогчид 536,916,797 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосноос 368,738,362 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж оны эцэст 104 хүнээс 167,948,135 төгрөгийн авлагатай байна. Үүнээс буцааж төлөх график хуваарьт хугацаа хэтэрсэн 79 хүний 110,705,217 төгрөг байна. Шүүхэд өгч хаяг тогтоолгосон, эрэн сурвалжлуулж байгаа 24 хүн 58,2 сая төгрөг. Нөхөн төлбөр нэхэмжилсэн шүүхийн шийдвэр гарсан 11 хүн 30,4 сая төгрөг, одоогоор шүүхэд өгсөн боловч зохих шийдвэр гараагүй 13 хүн байна.

Хүснэгт №4

№	Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох үндэслэл	Нөхөн төлбөр хүссэн өргөдлийн тоо	Нэхэмжилсэн дүн	Өргөдлийн шийдвэрлэлт						Тухайн онд шийдвэрлэгдээгүй өргөдөл		Буцаан төлөлт
				Даатгалын сангаас олгосон		Даатгалын хохирол үнэлгээний төлбөрт олгосон		Даатгалын сангаас олгохоос татгалзсан				
				тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	
1	Даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан /18.1.1/	35	105,391,965	25	67,769,061	5	551,500	8	31,728,904	2	5,894,000	
2	Даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан /18.1.2/	5	6,764,600	5	6,764,600	1	58,000	-	-	-	-	
3	Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус /18.1.3/	0	-	-	-	-	-	-	-			
4	Даатгагч дампуурсан /18.1.4/	0	-	-	-	-	-	-	-		-	
5	Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл /18.1.5/	2	5,756,000		-	-	-	2	5,756,000	-	-	
Дүн		42	117,912,565	30	74,533,661	6	609,500	10	37,484,904	2	5,894,000	102,539,186

Тайлбар: Буруутай тал нь хохирлыг хариуцаж барагдуулсан 1 тохиолдлын /18.1.1/-д 1,610,000 төгрөг байна.

Нийт 6 даатгалын тохиолдлын хохирол үнэлгээний хөлсөнд 609,500 төгрөгийг ЖДТХ-ийн 16.5-д заасны дагуу даатгалын сангаас олгосон.

2013 оны дүн	50	92,896,882	19	40,544,132	-	-	26	41,149,520	5	11,203,230	9,725,640
2014 оны дүн	91	201,631,161	64	150,724,960	46	3,223,400	14	23,145,566	13	27,760,635	60,651,872
2015 оны дүн	65	152,107,397	49	113,984,504	27	1,744,500	10	25,070,893	6	13,052,000	94,902,364
2016 оны дүн	72	179,100,440	64	157,129,540	19	1,463,000	2	2,070,000	6	19,900,900	100,919,300
2017 оны дүн	42	117,912,565	30	74,533,661	6	609,500	10	37,484,904	2	5,894,000	102,539,186
Нийт дүн	320	743,648,445	226	536,916,797	98	7,040,400	62	128,920,833	32	77,810,765	368,738,362

Тайлбар 2013-2017 онд нийтдээ даатгалын тохиолдлын буруутай этгээд нь 77,937,804 төгрөгийн бусдад учруулсан хохирлоо өөрөө хариуцан тухайн үед нь бэлнээр төлж барагдуулсан дүнг оруулаагүй.

2013 оноос хойш, Жолоочийн даатгалын сангаас нийт 226 даатгалын тохиолдлын хохирогчид 536,916,797 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосноос 368,738,362 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж оны эцэст 94 хүнээс 206,731,648 сая төгрөгийн авлагатай байна.

2.2 АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЧИГ ҮҮРЭГТЭЙ ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТАЛААР:

Мэдээллийн сан нь Даатгалын тухай хуулийн 12¹.3.1-д заасан чиг үүрэг болон Албан журмын даатгагчдын холбооны гишүүн, даатгагч, даатгуулагч нарт өөртэй нь холбоотой мэдээллээр, жолоочийн даатгалтай холбоотой хэрэг маргааныг хянан шийдвэрлэж буй төрийн байгууллага, албан тушаалтанд үнэ төлбөргүй мэдээллээр хангах үүрэг гүйцэтгэж байна. Холбооны гишүүдийнхээ ажлын уялдаа холбоог хангахад мэдээллийн сангийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн МИИС систем хяналт тавих чухал үүрэг гүйцэтгэж байна.

Даатгагч, зуучлагчид жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ хийхдээ манай холбооноос 2014 онд боловсруулж хэрэгжүүлсэн МИИС онлайн системийг ашигладаг.

Мэдээллийн сангийн найдвартай байдал, системийн хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах ажлын төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран системийн тайлбарыг гарган ажиллаж хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж хамгаалалтын түвшинг сайжруулсан. Шинээр хамгаалалтын файрвол төхөөрөмж нийлүүлэгдэн хос төхөөрөмжтэй болсон нь аль нэг төхөөрөмж эвдэрч гэмтсэн үед нөгөө төхөөрөмжд автоматаар сэлгэн залгагдаж ажиллах болсон. Шинээр IPS төхөөрөмжийг ажиллагаанд оруулж халдлага дайралтыг илрүүлэн бүртгэл хөтөлдөг болсон бөгөөд жилийн эцсийн байдлаар 120 гаруй эрсдэлтэй түвшиний халдлага бүртгэгдсэн байна.

Цаашид хамгаалалтын түвшинг улам нэмэгдүүлэх, холбогдох сургалтанд хамрагдах шаардлагатайг харуулж байна. Дата төвтэй холбогдох сүлжээний холболтонд доголдол гарч байсныг илрүүлж дата төв, мобинэттэй хамтран доголдлыг засварлав.

Холбооны үйл ажиллагааг өргөжүүлж, улам сайжруулахын тулд дагаж мөрдөх журам зааврыг бусад холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх ажлын хүрээнд Мэдээллийн сангийн мэдээлэл болон МИИС систем ашиглах гэрээг шинэчлэн боловсруулж, холбооны гишүүн 15 даатгалын компаниудтай тус гэрээг байгуулж, хамтран ажиллалаа. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийн дагуу даатгалын зуучлалын үйлчилгээ эрхлэгч 23 компани болон арилжааны 7 банкттай “Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн мэдээлэл, МИИС систем ашиглах гэрээ”-г шинэчлэн байгуулсан байна.

Мэдээллийн сангийн МИИС системийг ашигладаг даатгалын компани, зуучлагч нарын баталсан журмыг судалж нэгтгэн шинээр МИИС систем ашиглах нийтлэг журмын төсөл боловсруулан батлуулсан. МИИС системийн гэрээний гарын авлага, даатгалын тохиолдлын гарын авлага, даатгалын тохиолдлын дуудлага бүртгэх гарын авлага, нөхөн төлбөрийн гарын авлагыг шинэчлэн МИИС систем ашиглах нийтлэг журамд хавсралт байдлаар орууллаа.

Мэдээллийн санд даатгалын зуучлагч бүртгэх, үйл ажиллагаанд хяналт тавихад бэрхшээлүүд тулгарч байсан учраас “Жолоочийн даатгалын мэдээллийн санд даатгалын зуучлагч бүртгэлийн журам”-ыг шинээр боловсруулж батлуулсан. Мөн мэдээллийн сангийн мэдээлэл ашигласны төлбөрийг шинэчлэн тогтоох тухай удирдах зөвлөлөөр батлуулсан.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмыг удирдах зөвлөлийн гишүүдээс 2 удаа санал авч хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Тус журам батлагдсанаар мэдээллийн

аюулгүй байдлыг хангах талаар бодлогын түвшинд ахиц гарсан ба цаашид улам сайжруулах шаардлагатай.

2017 оны байдлаар санхүүгийн зохицуулах хороонд мэдээллийн сангийн сүүлийн 7 хоног бүрийн гэрээ, нөхөн төлбөрийн мэдээллийг нийт 42 удаа явуулсан байна.

2017 оны 5 дугаар сар мөн 8 дугаар саруудад хийгдсэн жолоочийн даатгалын гэрээний мэдээлэлд шалгалт хийж бүрэн бус гэрээний дэлгэрэнгүй судалгааг гаргав.

Нийт 913 гэрээ шалгаснаас 482 гэрээ нь буюу 52,9% нь бүрэн бус, ямар нэгэн байдлаар мэдээлэл дутуу, буруу хийгдсэн гэрээ байгаа нь шалгалтаар илэрсэн. Мөн 2017 онд мэдээллийн санд бүртгэгдсэн нөхөн төлбөрийн 10 сарын 1520 мэдээллийг түүвэрлэн сонгож 15 төрлийн үзүүлэлтээр шалгаж үзэхэд 72,4 хувь нь алдаатай, бүрэн бус байна.

Холбооны гишүүдийн уялдаа холбоог сайжруулж АЖДХ-ны үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд мэдээллийн санд шинээр бүртгэх мэдээлэл, гарч байгаа өөрчлөлтийн талаар мэдээ мэдээлэл зөвлөгөө өгөх уулзалтыг даатгалын компаниудтай хамтран 2017 оны 3 дугаар сарын 24-нд хийж харилцан санал солилцов. Даатгалын төлөөлөгчийн эрх олгох 2 удаагийн сургалтанд мэдээллийн сан болон МИИС системийн талаар тайлбарлан даатгалын гэрээ байгуулах талаар дадлага ажил орсон ба гэрээ байгуулах болон бусад холбогдох мэдээллээр суралцагчдыг хангав.

Мэдээллийн сангаас даатгалын компаниудын ажилтанд даатгалын тохиолдлын дуудлага бүртгэх сургалтыг 2 удаа, даатгалын тохиолдол бүртгэх сургалтыг 1 удаа зохион байгууллаа. Сургалтанд хамрагдсан даатгалын компанийн ажилчид даатгалын тохиолдлын дуудлага бүртгэх програм дээр нэмэлт өөрчлөлт оруулах талаар 15 санал өгсөн бөгөөд 5 саналыг тусгаж хэрэгжүүлсэн. Одоогийн байдлаар даатгалын тохиолдлын 3351 дуудлага бүртгэгдсэн байна.

Даатгалын сангаас нөхөн төлбөр олгохтой холбоотойгоор 60 жолоочийн даатгалын гэрээний лавлагаа мэдээллийг гарган өгч үйлчилсэн байна.

Төрийн болон ТББ-тай холбогдож мэдээлэл солилцох боломжийг нээх ажлын хүрээнд Зам тээврийн яаманд зохиогдсон Монгол улсад хэрэгжүүлж байгаа “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах төсөл”- ийн хүрээнд хийгдэх зам тээврийн ослын тухай мэдээллийн сангийн менежментийн системийг ашиглан шаардлагатай тоон мэдээлэл дээр үндэслэн судалгаа гаргах мөн зохих түвшний холболтыг хийснээр мэдээлэл солилцох боломж нээгдэнэ гэж үзэж байна. Зам тээврийн ослын бүртгэлийг цагдаагийн алба хаагч тусгай төхөөрөмж ашиглах цахимаар хийх явцад даатгалын гэрээ болон бусад холбогдох мэдээлэл харах байдлаар мэдээллийн санг бүрдүүлж, МИИС системд бүртгэгдэж байгаа даатгалын тохиолдлын мэдээлэл бүрэн бүрдэх нөхцөл бий болно гэж үзэж байна.

Авто Тээврийн үндэсний төвтэй хамтран ажиллаж "Мэдээлэл харилцан солилцох гэрээ"-ний төслийн талаар уулзалт хийж саналаа хүргүүлсэн ба Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага хяналтын төвтэй уулзалт хийж хамтран ажиллахаар гэрээ байгуулан ажиллав. Тус гэрээний үндсэн дээр даатгалын гэрээний зарим мэдээллийг тус төвд өгөх, тус төвөөс замын хөдөлгөөнд оролцож камерын хяналтанд өртсөн тээврийн хэрэгслийн дугаарыг манайд ирүүлдэг болсон.

Мэдээллийн сангийн үйл ажиллагааг дараах судалгааны дүнгээс харж болно.

Жолоочийн даатгалын гэрээний хувьд мэдээллийн сангийн мэдээллийг төрөлжүүлж авч үзвэл хувь хүний **465,791**, хуулийн этгээдийн **119,607**, мэргэшсэн болон C,D ангиллын жолоочийн **13,488**, дамжин өнгөрөхийн **6,793** гэрээ байгуулагдсан байна. Даатгалын компани тус бүрийн байгуулсан жолоочийн даатгалын гэрээний тоо, хураамжийн дүнгийн хэмжээг Хүснэгт №5 - аас харна уу.

Хүснэгт № 5. /Даатгалын компани болон гэрээний ангиллаар/

№	Нэрс	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн, CD		Дамжин өнгөрөх		Нийт гэрээний тоо	Нийт хураамжийн дүн
		Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн		
1	Соёмбо даатгал	19,786	778,440,172	7,228	677,679,427	498	13,209,233	10	1,094,682	27,522	1,470,423,514
2	Миг даатгал	77,094	2,982,074,452	19,959	1,529,473,198	1,335	38,377,929	80	6,513,787	98,468	4,556,439,366
3	Мөнх даатгал	685	25,357,636	548	49,280,666	186	5,212,843	5,238	404,877,613	6,657	484,728,758
4	Монгол даатгал	91,656	3,428,789,554	20,535	1,860,767,753	2,992	82,885,986	1,030	46,840,714	116,213	5,419,284,007
5	Практикал даатгал	37,983	1,373,680,164	9,562	834,914,491	1,372	35,835,897	224	13,259,392	49,141	2,257,689,944
6	Гэр даатгал	9,933	412,464,089	3,253	231,470,106	101	2,761,356	0	0	13,287	646,695,551
7	Улаанбаатар хотын даатгал	31	1,434,436	86	6,642,360	0	0	0	0	117	8,076,796
8	Номин даатгал	34,430	1,326,154,498	7,729	684,327,103	902	26,571,010	10	610,994	43,071	2,037,663,605
9	Тэнгэр даатгал	28,172	1,099,708,703	9,866	1,024,214,509	934	25,079,908	4	131,650	38,976	2,149,134,770
10	Бодь даатгал	69,065	2,627,678,158	11,385	916,314,413	693	17,810,161	187	11,253,822	81,330	3,573,056,554
11	Ган зам даатгал	79	3,521,157	247	19,853,220	71	1,907,070	0	0	397	25,281,447
12	Монре даатгал	35,184	1,368,975,183	9,711	725,140,604	406	11,589,036	0	0	45,301	2,105,704,823
13	Ард даатгал	29,618	1,092,008,225	7,245	622,803,154	1,013	27,575,368	3	302,412	37,879	1,742,689,159
14	Мандал даатгал	14,602	697,868,706	6,169	503,000,711	439	12,959,014	2	168,432	21,212	1,213,996,863
15	Хаан даатгал	17,473	660,009,721	6,084	570,056,797	2,546	86,877,490	5	417,739	26,108	1,317,361,747
	Нийт дүн	465,791	17,878,164,854	119,607	10,255,938,512	13,488	388,652,301	6,793	485,471,237	605,679	29,008,226,904

ОН	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн, CD		Дамжин өнгөрөх		Нийт гэрээний тоо	Нийт хураамжийн дүн
	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн		
2014 оны дүн	392345	12,517,686,000	94249	6,364,385,000	12830	429,944,000	432	340,780,000	499856	19,345,095,596.0
2015 оны дүн	406572	14,361,184,249	98506	7,324,645,983	15267	490,770,600	3911	241,921,071	524256	22,418,521,903.0
2016 оны дүн	432376	17,250,955,949	100506	8,552,636,583	13856	430,988,358	5307	384,368,959	552045	26,618,949,849.0
2017 оны дүн	465,791	17,878,164,854	119,607	10,255,938,512	13,488	388,652,301	6,793	485,471,237	605,679	29,008,226,904.0

График № 4. Жолоочийн даатгалын гэрээний тоо /Даатгалын компаниар/





График № 5. Жолоочийн даатгалын гэрээний хураамжийн харьцаа /Гэрээний ангиллаар/



Дээрх графикаас 2016 онд хувь хүний даатгалын гэрээний хураамжийн орлого 16,7%-иар өссөн бол 2017 онд 3,5%-иар өссөн үзүүлэлттэй байна. Өнгөрсөн онуудтай харьцуулахад хувь хүн, хуулийн этгээд, дамжин өнгөрөхийн гэрээний тоо тогтмол өссөн байна. Харин Мэргэшсэн С,Д ангиллын хураамжийн дүн өнгөрсөн оноос 9,8%-иар буурсан харагдаж байна.

Хүснэгт № 6. Жолоочийн даатгалын гэрээ /Газар нутгийн байршлаар/

№	Аймаг, нийслэл	Даатгалын гэрээний тоо		Хураамжийн дүн	
		/2016 он/	/2017 он/	2016 он	/2017 он/
1	Архангай	8,974	10,139	314,567,149	340,882,410
2	Баян-Өлгий	8,135	9,560	276,080,312	313,896,424
3	Баянхонгор	10,095	11,285	350,668,400	393,643,043
4	Булган	8,271	8,974	289,470,671	302,762,799
5	Говь-Алтай	7,012	7,642	242,042,416	255,922,197
6	Говьсүмбэр	2,432	2,374	99,138,911	93,796,367
7	Дархан-Уул	13,674	15,011	586,330,206	627,213,633
8	Дорноговь	10,097	11,927	394,939,827	460,893,762
9	Дорнод	8,832	10,988	318,097,310	321,185,910
10	Дундговь	7,096	11,927	234,723,577	460,893,762
11	Завхан	8,327	9,097	298,321,753	312,188,101
12	Орхон	17,949	19,443	763,793,293	816,399,048
13	Сэлэнгэ	14,421	16,625	589,446,500	657,029,755
14	Сүхбаатар	8,291	8,489	285,979,006	285,133,215
15	Төв	11,303	11,654	442,996,316	443,936,132
16	Увс	8,085	8,978	276,775,320	301,886,107
17	Улаанбаатар	332,611	362,449	17,863,528,952	19,472,035,419
18	Ховд	7,634	9,278	285,485,698	345,918,839
19	Хэнтий	9,456	10,888	333,334,216	363,290,037
20	Хөвсгөл	12,826	13,798	448,453,184	470,689,309
21	Өвөрхангай	13,236	14,688	465,163,906	517,683,662
22	Өмнөговь	15,446	18,046	953,009,982	1,185,031,854
	Нийт	544,203	605,679	26,112,346,905	29,008,226,904

/ Дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний тоо, үнийн дүн Хүснэгт №6-ын нийт дүнд ороогүй болно./**

2.2.1 Жолоочийн даатгалын нөхөн төлбөр


Албан журмын даатгагчдын холбооны даатгалын сангаас болон гишүүн 15 даатгалын компани 2017 онд нийт **28,782** даатгалын тохиолдолд **15,275,994,541** төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Хохирлыг эрсдэлийн ангилал тус бүрээр авч үзвэл тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан **27,392** даатгалын тохиолдолд **13,948,076,450** төгрөгийн нөхөн төлбөр, эд хөрөнгөнд хохирол учруулсан **956** даатгалын тохиолдолд **656,462,625** төгрөгийн нөхөн төлбөр, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан **380** даатгалын тохиолдолд **445,397,517** төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Даатгалын компани тус бүрийн хохирогчид олгосон нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээг Хүснэгт №7-оос харна уу.

Хүснэгт № 7. Нөхөн төлбөр /Даатгалын компани, эрсдлийн ангиллаар/

№	Даатгагч	Тээврийн хэрэгсэл			Бусад хөрөнгө		Амь нас		Эрүүл мэнд		НийтД/ Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн
		Он	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн		
1	Соёмбо даатгал	2016	789	384,884,612	11	6,233,460	3	13,066,750	8	15,295,010	811	419,479,832
		2017	851	435,999,639	19	13,984,537	0	0	20	33,522,553	890	483,506,729
2	Миг даатгал	2016	4562	2,096,081,375	71	47,413,544	9	31,319,220	85	74,596,447	4727	2,249,410,586
		2017	4,161	2,140,932,451	88	85,876,532	11	41,631,402	65	55,446,886	4,325	2,323,887,271
3	Мөнх даатгал	2016	27	14,146,010	0	0	0	0	0	0	27	14,146,010
		2017	35	17,616,600	2	670,100	0	0	1	227,000	38	18,513,700
4	Монгол даатгал	2016	4950	2,318,118,724	75	75,497,010	9	32,958,912	67	93,011,924	5101	2,519,586,570
		2017	4,923	2,452,475,654	77	79,040,878	10	59,664,726	59	63,213,351	5,069	2,654,394,609
5	Практикал даатгал	2016	1851	1,004,044,792	30	30,549,792	2	9,760,000	43	44,326,084	1926	1,088,680,668
		2017	1,749	1,031,566,082	18	21,446,346	4	15,601,400	27	27,513,323	1,798	1,096,127,151
6	Гэр даатгал	2016	208	82,154,813	2	1,170,790	1	4,000,000	2	1,351,944	213	88,677,547
		2017	676	318,770,836	3	3,210,120	0	0	4	2,099,960	683	324,080,916
7	УБ хотын даатгал	2016	7	3,685,000	0	0	0	0	0	0	7	3,685,000
		2017	3	958,600	0	0	0	0	0	0	3	958,600
8	Номин даатгал	2016	1741	722,738,948	29	25,432,985	2	10,238,670	36	51,452,033	1808	809,862,636
		2017	1,744	867,942,777	33	40,924,710	3	12,376,000	32	42,854,663	1,812	964,098,150
9	Тэнгэр даатгал	2016	1961	970,819,996	59	44,435,211	2	11,500,000	22	33,136,647	2044	1,059,891,854
		2017	1,744	956,548,012	135	69,610,667	1	5,000,000	23	42,458,729	1,903	1,073,617,408
10	Бодь даатгал	2016	4369	1,823,163,352	4	2,914,881	2	8,081,500	8	4,731,298	4383	1,838,891,031
		2017	3,592	1,726,253,586	28	22,832,670	2	3,488,203	35	33,587,152	3,657	1,786,161,611
11	Ганзам даатгал	2016	14	6,706,100	0	0	0	0	1	120,000	15	6,826,100
		2017	16	10,351,233	0	0	0	0	1	1,054,022	17	11,405,255
12	Монре даатгал	2016	2036	826,294,154	0	0	0	0	0	0	2036	826,294,154
		2017	2,639	1,405,733,125	39	37,465,981	2	5,099,000	41	72,824,042	2,721	1,521,122,148
13	Ард даатгал	2016	1916	906,316,673	26	22,412,174	9	24,328,880	46	41,152,102	1997	994,209,829
		2017	1,357	676,919,360	21	22,239,790	8	29,991,000	35	34,557,384	1,421	763,707,534
14	Мандал даатгал	2016	4249	1,722,329,764	32	21,076,829	0	0	0	0	4281	1,743,406,593
		2017	2,568	1,164,192,523	490	258,272,594	10	33,060,680	33	30,365,954	3,101	1,485,891,751
15	Хаан даатгал	2016	1022	542,992,456	4	1,132,247	0	0	17	10,351,671	1043	554,476,374
		2017	1,306	674,362,599	3	887,700	2	13,839,800	3	4,897,948	1,314	693,988,047
16	АЖДХ	2016	60	149,457,884	3	7,452,000	0	0	1	219,656	64	157,129,540
		2017	29	73,759,111	0	0	0	0	1	774,550	30	74,533,661
Нийт дүн		2016	29762	13,573,934,653	346	285,720,923	39	145,253,932	336	369,744,816	30483	14,374,654,324
		2017	27,392	13,948,076,450	956	656,462,625	53	219,752,211	380	445,397,517	28,782	15,275,994,541

График № 6. Нөхөн төлбөрийн дүн, даатгалын компаниар /мянган төгрөг/



Хүснэгт № 8. Нөхөн төлбөр /Газар нутгийн байршлаар/

№	Аймаг, нийслэл	Даатгалын тохиолдлын тоо		Нөхөн төлбөрийн дүн	
		2016 он	2017 он	2016 он	2017 он
1	Завхан	60	50	35,869,152	45,380,175
2	Баянхонгор	68	89	23,360,929	51,506,703
3	Ховд	39	27	26,473,570	34,393,141
4	Архангай	58	94	35,873,275	71,259,273
5	Говь-Алтай	55	49	41,469,359	30,565,808
6	Дундговь	83	71	61,304,849	47,130,013
7	Булган	67	61	85,668,955	84,637,453
8	Увс	72	81	36,596,760	41,691,527
9	Баян-Өлгий	77	82	43,516,993	41,784,848
10	Сүхбаатар	65	61	42,801,264	43,908,947
11	Говьсүмбэр	33	33	30,909,475	24,876,229
12	Хэнтий	88	90	65,362,796	102,218,713
13	Өвөрхангай	128	100	98,304,095	101,387,475
14	Хөвсгөл	89	80	42,355,989	46,661,522
15	Өмнөговь	130	128	119,368,951	198,163,253
16	Дорноговь	138	153	86,691,190	106,791,436
17	Дорнод	136	176	94,944,310	100,564,449
18	Төв	219	208	250,849,776	300,065,049
19	Сэлэнгэ	244	226	184,363,984	216,731,976
20	Дархан-Уул	340	365	191,731,106	191,286,452
21	Орхон	634	608	339,682,236	304,847,042
22	Улаанбаатар	27,596	25,950	12,280,025,770	13,090,143,057
Нийт:		30,483	28,782	14,217,524,784	15,275,994,541

Жолоочийн даатгалын хамрагдалт, нөхөн төлбөрийн идэвхжилтийн судалгаа

Жолоочийн даатгалд хамрагдалт **4,5,6** саруудад хамгийн өндөр буюу **265,568** даатгалын гэрээ байгуулагдсан байна. Энэ нь 2017 онд байгуулагдсан нийт гэрээний **43,84%** хувьтай тэнцүү байна.

График №7. Жолоочийн даатгалд хамрагдалт /сараар/





График №8. Даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн идэвхжилт /сараар/



Хүснэгт № 9. Нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээг бүлэглэж авч үзвэл:

№	Нэрс	Нөхөн төлбөрийн тоо		Нөхөн төлбөрийн нийт дүн	
		2016 он	2017 он	2016 он	2017 он
1	200,000 хүртэлх	11,036	9,667	1,459,538,372	1,213,266,616
2	200,000-500,000 хүртэлх	12,167	11,085	4,038,804,235	4,345,070,888
3	500,000-800,000 хүртэлх	3,396	3,538	2,122,437,058	2,272,017,195
4	800,000-1,000,000 хүртэлх	1,105	1,299	986,804,756	1,052,890,402
5	1,000,000-1,500,000 хүртэлх	1,265	1,485	1,536,611,944	1,605,390,835
6	1,500,000-2,000,000 хүртэлх	559	626	960,951,540	1,075,853,436
7	2,000,000-3,000,000 хүртэлх	450	545	1,079,172,933	1,311,061,358
8	3,000,000-4,000,000 хүртэлх	233	219	793,380,598	746,619,498
9	4,000,000-5,000,000 хүртэлх	125	123	554,420,852	549,137,998
10	5,000,000-8,000,000 хүртэлх	136	175	709,088,850	916,417,232
11	8,000,000-10,000,000 хүртэлх	9	14	81,876,625	123,561,393
12	10,000,000	2	6	51,566,562	64,707,690
	Нийт дүн	30,483	28,782	14,374,654,325	15,275,994,541

График № 9. Нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ.



Даатгуулагчийн бүлэг, нөхөн төлбөрийн судалгаа

Жолоочийн хариуцлагын даатгалаар 2017 онд даатгуулсан даатгуулагчийн бүлэг, нөхөн төлбөр авсан тоогоор дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт №10 Даатгуулагчийн бүлэг, нөхөн төлбөр авсан тоо:

Бүлэг	Даатгуулагчийн тоо	Нөхөн төлбөр аваагүй	1 удаа нөхөн төлбөр авсан	2 удаа нөхөн төлбөр авсан	3 удаа нөхөн төлбөр авсан	4 болон түүнээс дээш нөхөн төлбөр авсан
0	247	211	15	15	3	3
1	3,803	3,273	343	123	43	21
2	19,804	19,511	225	49	17	2
3	13,098	12,917	132	37	8	4
4	8,227	8,112	82	22	8	3
5	16,728	16,522	144	49	10	3
6	13,339	12,577	534	158	49	19
7	112,956	105,914	5,016	1,405	402	222
8	98,072	94,264	2,768	730	221	88
9	98,229	95,533	2,034	474	150	38
10	91,558	89,611	1,478	327	108	34
11	67,991	66,652	1,007	230	85	17
12	45,376	44,630	546	144	42	14
13	30,150	29,638	399	81	28	4
М	563	434	77	28	15	9
Нийт	620,141	599,799	14,800	3,872	1,189	481

2.2.2. Жолоочийн даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн харьцаа

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй 15 даатгалын компани 2017 онд жолоочийн даатгалын хураамжийн орлогоор **29,008,226,904** төгрөг олж, **15,201,460,880** төгрөгийг нөхөн төлбөрт олгосон байна. Хураамжийн орлогод нөхөн төлбөр **52,4%** -ийг эзэлж байгаа нь өмнөх оны нөхөн төлбөрийн дүнтэй харьцуулахад **1,01%** -иар буурсан байна.

Жолоочийн даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн харьцааг даатгагч бүрээр харуулбал:

Хүснэгт №11

№	Нэрс	Нийт хураамжийн дүн /төг/		Олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн /төг/		Хураамжийн орлогод н/т-ийн эзлэх хувь	
		2016 он	2017 он	2016 он	2017 он	2016 он	2017 он
1	Соёмбо даатгал	1,022,121,075	1,470,423,514	419,479,832	483,506,729	41.04%	32.9%
2	Миг даатгал	3,827,443,384	4,556,439,366	2,249,410,586	2,323,887,271	58.77%	51.0%
3	Мөнх даатгал	413,000,962	484,728,758	14,146,010	18,513,700	3.43%	3.8%
4	Монгол даатгал	5,010,171,796	5,419,284,007	2,519,586,570	2,654,394,609	50.29%	49.0%
5	Практикал даатгал	2,304,495,080	2,257,689,944	1,088,680,668	1,096,127,151	47.24%	48.6%
6	Гэр даатгал	237,571,588	646,695,551	88,677,547	324,080,916	37.33%	50.1%
7	Улаанбаатар хотын даатгал	9,640,520	8,076,796	3,685,000	958,600	38.22%	11.9%
8	Номин даатгал	1,757,112,303	2,037,663,605	809,862,636	964,098,150	46.09%	47.3%
9	Тэнгэр даатгал	1,836,776,436	2,149,134,770	1,059,891,854	1,073,617,408	57.70%	50.0%
10	Бодь даатгал	3,238,041,765	3,573,056,554	1,838,891,031	1,786,161,611	56.79%	50.0%
11	Ганзам даатгал	24,712,862	25,281,447	6,826,100	11,405,255	27.62%	45.1%
12	Монре даатгал	1,665,342,968	2,105,704,823	826,294,154	1,521,122,148	49.62%	72.2%
13	Ард даатгал	1,561,005,071	1,742,689,159	994,209,829	763,707,534	63.69%	43.8%
14	Мандал даатгал	2,770,257,858	1,213,996,863	1,743,406,593	1,485,891,751	62.93%	122.4%
15	Хаан даатгал	941,256,181	1,317,361,747	554,476,374	693,988,047	58.91%	52.7%
	Нийт:	26,618,949,849	29,008,226,904	14,217,524,784	15,201,460,880	53.41%	52.4%

*/*Үүнд Албан журмын даатгагчдын холбооноос олгосон нөхөн төлбөрийн дүн ороогүй болно/**

Жолоочийн даатгалын хамрагдалт

2017 онд жолоочийн даатгалд хамрагдалтыг өмнөх 2016 оны мөн үеийн жолоочийн даатгалын тоо мэдээтэй харьцуулж харуулбал:

Хүснэгт №12. Жолоочийн даатгалд хамрагдалт /Өмнөх онтой харьцуулахад/

Д/д	Үзүүлэлт	2016.12.31	2017.12.31
1	Даатгалын гэрээний тоо	552,045	605,679
2	Даатгалын хураамж /төг/	26,618,949,849₮	29,008,226,904₮
3	Нөхөн төлбөр авсан тоо	30,483	28,782
4	Олгосон нөхөн төлбөр /төг/	14,374,654,324₮	15,275,994,541₮
5	Дундаж хураамжийн дүн	48,218₮	47,893₮
6	Дундаж нөхөн төлбөрийн дүн	471,562₮	530,748₮
Жолоочийн даатгалд хамрагдалт			8,8% хувиар өсөв

2017 оны байдлаар жолоочийн даатгалд хамрагдалт өнгөрсөн онтой харьцуулахад гэрээний тоо **8,8%** -иар, хураамжийн орлого **8,2%** - иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. 2016 онд **30,483** даатгалын тохиолдол гарч **14,374,654,324** төгрөгийн нөхөн төлбөр олгосон бол 2017 онд нийт **28,782** даатгалын тохиолдол гарч **15,275,994,541** төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Үүнээс үзэхэд 2017 онд даатгалын тохиолдлын тоо **5,5%**-иар буурч, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ **5,9%**-иар өссөн үзүүлэлттэй байна. Мандал даатгал ХХК. Энэ бүтээгдэхүүний хувьд алдагдалтай ажилласан асуудлыг хороотой хамтарч ярилцах нь зүйтэй гэж үзэж байна.

График №10. Даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн тоо





График №11. Даатгалын хураамж, нөхөн төлбөрийн дүн



2.2.3. Жолоочийн даатгалд зуучлагчдын үүрэг өсч байна.

Жолоочийн даатгалын гэрээ хийхэд зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 29 зуучлалын компани 2017 онд **220,369** жолоочийн даатгалын гэрээ байгуулж, **9,936,279,324** төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. 2017 оны нийт гэрээний тоонд зуучлагчдын эзлэх хувь **36,41%**, нийт хураамжийн дүнд эзлэх хувь **34,25%** байна. Үүнээс 7 арилжааны банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр банкнууд нь **76,402** гэрээ байгуулж, **3,344,664,952** төгрөгийн даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

Хүснэгт № 13. Жолоочийн даатгалын гэрээ хийсэн зууч компаниар харуулбал:

Д/Д	Даатгалын зууч компани	Жолоочийн даатгалын гэрээний тоо		Жолоочийн даатгалын гэрээний хураамж		Нийт гэрээний тоонд эзлэх хувь		Нийт гэрээний хураамжид эзлэх хувь
		2016 он	2017 он	2016 он	2017 он	2016 он	2017 он	2017 он
1	Сүрэг хараацай	51,136	48,390	2,432,145,628	2,251,759,485	9.26%	7.99%	7,76
2	Смарт брокерс	18,735	28,050	857,572,111	1,254,715,724	3.39%	4.63%	4,33
3	Хаан банк	3,731	8,550	136,055,972	298,538,141	0.68%	1.41%	1,03
4	Лоялти солюшн	1,219	2,395	48,282,479	106,111,506	0.22%	0.40%	0,37
5	Эрсдлийн шийдэл	11,382	7,919	529,523,439	374,789,830	2.06%	1.31%	1,29
6	Ачит-ундарга	155	92	9,065,854	7,256,862	0.03%	0.02%	0,03
7	Төрийн банк	15,650	17,524	575,004,390	630,821,591	2.83%	2.89%	2,17
8	Капитал банк	78	58	5,201,279	3,367,860	0.01%	0.01%	0,01
9	Монгол бичээч	5,880	4,794	282,953,458	226,256,021	1.07%	0.79%	0,78
10	Ариг банк	31	20	2,026,078	1,007,353	0.01%	0.003%	0,003
11	Дэвжих дэлгэрэх	8,524	4,946	422,690,340	249,145,883	1.54%	0.82%	0,86
12	ҮХО-ын банк	45,879	44,935	2,168,004,697	2,116,171,998	8.31%	7.42%	7,30
13	ХАС банк	448	405	21,980,640	18,808,240	0.08%	0.07%	0,06
14	Мастер шийдэл	138	31	6,795,838	3,008,475	0.02%	0.01%	0,01
15	ХХБ	2,536	4,910	140,552,617	275,949,769	0.46%	0.81%	0,95
16	Lbbrokerage ХХК	9,120	10,087	425,396,041	439,556,500	1.65%	1.67%	1,52
17	Си эн эн икс	4,283	10,229	186,276,556	453,291,887	0.78%	1.69%	1,56
18	Цагаан гэрэлт	4,206	3,969	171,769,415	156,349,890	0.76%	0.66%	0,54
19	Тод капитал	12,764	15,024	600,573,134	686,491,033	2.31%	2.48%	2,37
20	Эй Эс Ай Би	108	25	6,165,019	1,858,164	0.02%	0.003%	0,14
21	Эс Ай Би Эс	1,720	904	79,036,732	42,060,513	0.31%	0.15%	0,14
22	Нэйшнл Эженси	2,968	4310	142,335,472	203,252,732	0.54%	0.71%	0,70

23	Эм ай би	31	47	1,863,097	3,297,914	0.01%	0.01%	0.01
24	Эм Жи Ай Би	-	1003	-	47,165,461	-	0.17%	0.16
25	Ивээлт очир	-	388	-	18,933,197	-	0.06%	0.07
26	Эс Ти Ди	-	269	-	12,563,430	-	0.04%	0.04
27	Ваяснью Солюшин	-	640	-	30,779,559	-	0.11%	0.11
28	Бэст Солюшин	-	455	-	22,970,306	-	0.08%	0.08
Нийт		200,7	220,369	9,251,430,666	9,936,279,324	34,75%	36.41%	34,25%

*Нийт жолоочийн даатгалын гэрээнд зуучлагчдын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1,66 хувиар өсчээ.

2.2.4. Жолоочийн даатгалд хамрагдсан тээврийн хэрэгслийн судалгаа

Тээврийн хэрэгслийн ангиллаар нь 2017 оны даатгалын гэрээний тоог харвал “В” ангиллын тээврийн хэрэгсэл **514,988** гэрээ байгуулж, **22,430,839,723** төгрөгийн хураамжийн орлого олсон байна.


Хүснэгт №14. Жолоочийн даатгалын гэрээ /Тээврийн хэрэгслийн ангилал/

№	Зүйл	Гэрээний тоо			Хураамжийн дүн		
		2015 он	2016 он	2017 он	2015 он	2016 он	2017 он
1	А	13,290	12,313	12,143	165,101,945	162,368,596	155,840,108
2	В	437,576	481,624	514,988	17,124,704,545	21,320,990,623	22,430,839,723
3	С	38,306	38,584	44,683	3,275,618,925	3,636,105,198	4,434,833,304
4	Д	15,134	14,889	15,065	1,198,021,870	1,315,067,029	1,324,135,219
5	М	4,223	4,189	4,313	107,519,930	119,571,828	124,984,696
6	Бусад	472	446	999	57,291,269	64,846,575	148,941,553
Нийт		486,758	509,001	592,191*	18,893,910,796	21,928,258,484	28,619,574,603*

/* Мэргэшсэн жолоочийн гэрээ, хураамжийн дүн ороогүй болно./

Тээврийн хэрэгслийн бүртгэл, оношилгоо, татвар болон жолоочийн даатгалд хамрагдалтын үзүүлэлтийг сүүлийн 4 жилийн байдлаар график 10-аар харуулбал:

График № 12



2.2.5. Мэдээллийн сангаас үйлчилгээ үзүүлж олгосон лавлагаа

Мэдээллийн сангийн лавлах 70121177 дугаарын утсанд ирсэн иргэд, даатгалын компани, зуучлагчид, хамтран ажилладаг төрийн болон хувийн компаниудын санал гомдол, хүсэлт гаргасан 2868 гаруй дуудлагад хариу өгч иргэд, даатгагч, зуучлагчдад мэдээлэл солилцох боломж олгожээ.

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн лавлах утсанд 2016, 2017 онуудад ирсэн лавлагаа, мэдээллийн дуудлага.

Хүснэгт №15. Мэдээллийн сангийн утсанд ирсэн дуудлага

№	Лавлах утсанд ирсэн дуудлагын төрөл	2016 он	2017 он
1	Нөхөн төлбөрийн дуудлага	869	753
2	Даатгалын компаний ажилтаны лавлагаа	3	23
3	Хууль тогтоомжийн лавлагаа	30	5
4	Даатгалын сангийн лавлагаа	42	57
5	Мэдээллийн сангийн лавлагаа	453	238
6	Даатгалын гэрээний	904	1018
7	Санал гомдолын	41	21
8	Журам лавлагааны	-	75
9	АЖДХ ажилтны лавлагаа	80	42
10	Даатгалын компаний утасны дугаар, хаяг байршил асуусан	64	33
11	Бусад дуудлага	93	603
Дүн		2579	2868

Мэдээллийн сангийн үйлчилгээ өнгөрсөн оны мөн үеэс 289 дуудлага буюу 11,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Бусад дуудлага огцом 510-аар нэмэгдсэн нь сонирхол татаж байгаа ба дахин ангилал хийх шаардлагатайг харуулж байна.

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн лавлагааг цахим хэлбэрээр 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Холбооны гишүүн даатгалын компани болон зуучлагч компани, төрийн байгууллагуудад 1,948,537 даатгуулагч болон тээврийн хэрэгслийн лавлагаа мэдээллийг олгосон байна.

Хүснэгт №16. Мэдээллийн сангийн лавлагаа

№	Нэрс	МИИС Лавлагааны тоо	
1	SmartCar	244,430	412,918
2	Замын цагдаагийн газар /ЗЦУТ/	531,386	217,044
3	Төрийн 25 үйлчилгээ	16,225	91,663
4	Police Terminal	100	470
Нийт		792,141	722,095
Даатгалын компани, зууч нарт олгосон			
5	Даатгалын компаниуд	863,616	892,511
6	Даатгалын зууч компаниуд	234,292	222,105
7	АЖДХ	32,113	33,206
8	Нийслэлийн замын цагдаагийн хэлтэс	26,375	25,263
Нийт		1,156,396	1,173,085

2017 онд Даатгалын компаниудын шуурхай албаны утсанд ирсэн дуудлагын тоо, даатгалын тохиолдлын үзлэгийн тэмдэглэлийн мэдээлэл:

Хүснэгт № 17

Д/Д	Даатгалын компанийн нэрс	Шуурхай албаны утсанд ирсэн дуудлагын тоо	Даатгалын тохиолдлын үзлэгийн тэмдэглэл	Шуурхай албаны утсанд ирсэн дуудлагын тоо	Даатгалын тохиолдлын үзлэгийн тэмдэглэл
		2016		2017	
1	Номин даатгал	2,971	-	1812	1812
2	Бодь даатгал	10,042	100,72	3657	3657
3	Мандал даатгал	6,875	4,395	3078	-
4	Монгол даатгал	8,523	-	5069	5069
5	Миг даатгал	6,907	5,260	3791	3791
6	Монре даатгал	-	-	2721	2721
7	Ард даатгал	1,401	-	1706	952
8	Тэнгэр даатгал	-	-	1982	1962
9	УБ хотын даатгал	-	-	4	4
10	Практикал даатгал	-	-	-	2020
11	Мөнх даатгал	-	-	38	34
12	Соёмбо даатгал	1,144	-	890	890
13	Ган зам даатгал	19	14	18	17
14	Хаан даатгал	-	-	1314	1314
15	Гэр даатгал	329	-	208	203
	Нийт	38,211	19,741	28,305	26,463

Мэдээллийн сан даатгалын компани, даатгалын зуучлагч нарт жолоочийн хариуцлагын даатгалыг хэрхэн хийх, даатгагч нарт хураамжийн хэмжээг зөв тооцох, холбогдох хууль журмыг тайлбарлах талаар холбогдох сургалт нэгдсэн байдлаар болон тухайн компанид очиж тайлбарлаж сургалт хийх зэрэг ажлыг тогтмол хийж байна. Энэ ажлыг цаашид шинэ арга хэлбэрээр өргөжүүлэх болно.

Даатгалын компаниудтай улирал бүр хийдэг тайлан тулгалтын явцад гардаг хүндэрлүүдийн нэг бол тайлан тулгалтын мэдээний бүрэн бус байдал. Зарим компаниуд санхүүгийн тайланд тусгагдсан дүн нь МИИС системд бүртгэгдсэн дүнгээс зөрсөн байдлыг бүрэн тайлбарласан албан бичиг, баримт ирүүлдэггүй. Зөрсөн шалтгаанаа урьд оны авлага орж ирсэн эсвэл цуцалсан гэрээний дүн гэж тайлбарлах нь илүүтэй байна. Цаашид зөрүүг арилгах, бууруулах тал дээр мэдээллийн сангийн зүгээс нэгдсэн тайлан тулгалтын маягтыг батлуулах, хяналт шалгалтыг улам нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Даатгалын гэрээ болон нөхөн төлбөрийн мэдээлэл бүртгэх талаар утсаар лавлах нь багассан

боловч даатгалын компани болон зууч компаниудын шинэ ажилтан нь хангалттай мэдээлэлгүй байгаа нь ажилд хүндрэл учруулж байна. Жишээлбэл нөхөн төлбөр авсан хүний бүлэг нь даатгалын тохиолдол болсон өдрөөс нэг жилийн хугацаанд арилахгүй бөгөөд даатгал хийх болгонд нэмэгдэх талаар мэдэхгүй. Иймд даатгалын компани болон зууч компаниудад шинээр орсон ажилчдад сургалт зохион байгуулсан ажлыг албан ёсоор хийж хэвшүүлэх шаардлагатай байна.

Үүнээс эхний ээлжинд даатгуулагчийн хаяг зөв бүртгэх талаар арга хэмжээ авч нийт даатгагч, зуучлагч нарт сургалт явуулах, анхааруулах, МИИС системд хаяг бүртгэх талбарыг сайжруулах, түүний мэдээлэлд хяналт тавих автомат систем хийх шаардлагатай нь харагдаж байна.

Цаашид мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх бүх л гуравдагч системд дээрх шаардлага тавих нь зүйтэй. Чанаргүй мэдээллээс болж Замын хөдөлгөөний удирдлагын төвөөс манайд хандаж яаралтай засаж сайжруулах санал тавьж байгааг анхаарч, ийм шалгалтыг улирал бүр хийж чанарын хувийг тогтоох, түүнийг дээшлүүлэх холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Цаашид даатгалын дуудлага, даатгалын үзлэгийн тэмдэглэлийн мэдээллийг мэдээллийн санд бүрэн, чанартай оруулах талаар хяналт тавьж ажиллах хэрэгцээ байна

2.3 ДААТГАГЧ, ДААТГУУЛАГЧ, ХОХИРОГЧ, ИРГЭНЭЭС ДААТГАЛЫН ТОХИОЛДЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫГ ШУУРХАЙ ҮНЭН ЗӨВ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖИЙГ ДААТГАГЧ, ДААТГУУЛАГЧ, ХОХИРОГЧИД БҮРДҮҮЛЭХ, ЧИГ ҮҮРЭГТЭЙ ШУУРХАЙ АЛБАНЫ ТАЛААР:

Шуурхай алба нь Даатгалын тухай хуулийн 12^{1.3.2}; Жолоочийн даатгалын тухай хуулийн 25.2 дахь заалтуудыг хэрэгжүүлж хохирогчдод туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ салбарын шуурхай албаны үйл ажиллагаанд хяналт тавьж зааварчилгаа өгөх, орон нутгийн замын цагдаагийн тасаг болон авто тээврийн газруудтай хамтран шалгалт хийж даатгалын зөрчилтэй жолоочийг илрүүлэх, зөрчлийг арилгуулах, иргэд, даатгуулагчдыг мэдээ мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэж байна.

2017 оноос Даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан төлүүлэх ажилд анхаарал төвлөрүүлсэн нь үр дүнгээ өгсөн болно.

2017 онд, Даатгалын тухай болон Жолоочийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, зам тээврийн ослыг бууруулахад чиглүүлсэн ажил зохион байгуулах, ажилтнуудын ажлын давхардлыг арилгах, ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, нийслэл, орон нутгийн замын цагдаагийн тасаг, авто тээврийн газар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж даатгалын зөрчилтэй этгээдийг илрүүлэх, зөрчлийг арилгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2017 оны 11 дүгээр сарын 6-нд Шуурхай албаны дарга, дуудлагын ажилтны ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталлаа. Даатгалын шуурхай албанд тавигдах нийтлэг шаардлага, ач холбогдлыг тусгасан журам боловсруулах, түүнийг даатгагчдын холбооны болон түүний гишүүн даатгагч нарт жигд мөрдүүлэхэд цаашид анхаарал тавих шаардлага байгаа юм.

2017 онд Даатгалын сангийн 13 дуудлага хүлээн авч 2 нь даатгалын тохиолдлын газар дээр, 8 нь нөхөн төлбөр гаргуулахаар материал бүрдүүлэх явцдаа тохиролцон хохирлоо өөрсдөө барагдуулахаар зохицож, буруутай 2 этгээдийн нөхөн төлбөрийг хохирогчид олгуулахаар Даатгалын санд шилжүүлж, 1 тохиолдлын буруутай этгээд нь даатгалтай байсан байна.

Шуурхай албаны дуудлагын 2 ажилтанд өгсөн үүрэг даалгаврын дагуу 2014, 2015 онд нөхөн төлбөр авсан боловч буцаан төлөөгүй 2014 оны 24, 2015 оны 30 буруутай этгээдээс төлбөрийг

нэхэмжилж 2014 оны 4 этгээдийн 5,644,940 төгрөг, 2015 оны 14 этгээдийн 13,458,170 төгрөгийн, нийт 19,103,110 төгрөгийн нөхөн төлбөрийг бүрэн барагдуулжээ.

2017 онд шуурхай албаны дуудлагын утсанд 2013 дуудлага, мэдээлэл, орон нутгийн салбаруудын дуудлагын утсанд 9610 дуудлага, мэдээллийг тус тус хүлээн авснаас жолоочийн хариуцлагын даатгалын 109 тохиолдлын дуудлагыг тухай бүр хүлээн авч үйлчилсэн байна.


2017 онд Холбооны шуурхай албанд хүлээн авсан 11623 /орон нутгийн салбаруудын лавлах утсанд ирсэн лавлагаа мэдээллийн тоотой нэгдсэн дүн/ дуудлага, мэдээллийн үйлчилгээг /хүснэгт 15-аас/ дуудлагын төрлөөр задалж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж харуулбал:

Хүснэгт №18

№	Лавлах утсанд ирсэн дуудлагын төрөл	2016 он	2017 он
1	Даатгалын тохиолдлын /Даатгалын сангийн дуудлагын хамт/ дуудлага	861	109
2	Хууль тогтоомжийн лавлагаа	1386	1002
3	Мэдээллийн сангийн лавлагаа	1931	1310
4	Даатгалын сан, нөхөн төлбөрийн лавлагаа	1167	767
5	Даатгалын компаний утас, байршлын лавлагаа	3316	1731
6	Санал гомдол	377	378
7	Бусад мэдээлэл	6975	6326
Дүн		16013	11623

Холбооны шуурхай дуудлагын утсанд ирсэн 11623 /орон нутгийн салбаруудтай нэгдсэн дүн/ дуудлага, мэдээллийг графикаар харуулбал:

График № 13




Холбооны дуудлагын утсанд ирсэн дуудлага, мэдээллийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:

Хүснэгт № 19


Үзүүлэлт	ДТ-ын дуудлага	Хууль тогтоомжийн лавлагаа	МС-ийн лавлагаа	ДС-ийн лавлагаа	Санал гомдол	ДК-ийн утас, байршил	бусад	нийт
2016	218	188	573	187	123	452	673	2414
2017	41	218	433	233	20	428	640	2013

Холбооны Ажлын албаны дуудлагын утсанд ирсэн дуудлага, мэдээллийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан графикаар харуулбал:

График № 14



2017 оноос эхлэн хийгдэж буй дэвшилтэд нэг ажил бол Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний хяналт, удирдлагын төвтэй мэдээлэл солилцож байгаа явдал юм. Тухалбал 2017.05.01-2017.05.22; 2017.10.23-2017.12.07 хооронд замын хөдөлгөөнд оролцож замын хөдөлгөөнийг хянах



телекамерт бичигдсэн **5731** тээврийн хэрэгслийн марк, модель, улсын дугаар, өнгө гэсэн мэдээлэл хүлээн авч тээврийн хэрэгслийн мэдээллээр хайлт, тулгалт хийснийг хүснэгт №20, график №15-аар харуулбал:

Хүснэгт № 20

Д/Д	Үзүүлэлт	Тоо
1	Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан	3646
2	Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдаагүй техникийн улсын хяналтын үзлэгт оруулсан	256
3	Жолоочийн хариуцлагын даатгалд хамруулалгүй улсын бүртгэлд бүртгэсэн эсвэл Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө бүртгэгдсэн	935
4	Улсын дугаарын үсэг сольж бичсэн (Л,П), 0000..-оор даатгалын гэрээ байгуулаад улсын дугаар авсны дараа солиулаагүй, арлын дугаар дундаа зураастай, зураасгүй бичигдсэн	396
5	Даатгалын хугацаа дууссан	495
6	Бүртгэлгүй улсын дугаар ашиглаж байгаа	3

Дээрх хүснэгтийг График № 15-р харуулбал:

Хамтран ажиллах гэрээ, Санамж бичгийн хүрээнд замын цагдаагийн алба болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран батлагдсан удирдамжийн дагуу нийслэл болон орон нутгийн авто замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүдэд шалгалт хийж нийслэлийн 3981 тээврийн хэрэгслээс 299 даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа хэтэрсэн зөрчлийг илрүүлж даатгалд хамруулсан байна. Орон нутгийн хэмжээнд, нийт 12403 тээврийн хэрэгслийг шалгаснаас 676 даатгалын зөрчилтэй тээврийн хэрэгслийг илрүүлж зөрчлийг бүрэн арилгуулсан байна.

2017 онд, Замын цагдаагийн албатай хамтран Авто СОС ХХК болон хэд хэдэн даатгалын компаний шуурхай албаны үйл ажиллагаатай танилцаж цаашид шуурхай алба хэрхэн ажиллах тухай, шуурхай албаны ажлын арга барилын талаар ярилцсан байна. Мөн АЖДХолбооны удирдлага, холбогдох ажилтнууд Нийслэлийн шуурхай удирдлагын төв, яаралтай тусламж үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай танилцаж цаашид шуурхай албыг нэгдсэн журмаар зохион байгуулах боломжийн талаар судалгаа хийлээ.


Даатгалын компаниуд тус тусдаа шуурхай албаны үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь оновчгүй шийдэл байх бөгөөд даатгуулагчид болон иргэдэд үйлчилгээгээ түргэн шуурхай хүргэхэд бэрхшээлтэй хэд хэдэн асуудлууд байна. Тухайлбал, шуурхай албаны дуудлагыг Авто Сос ХХК 70003000, Монгол даатгал ХХК 70170000, 1800-1990, Бодь даатгал 70004800, 99054800, Ард даатгал 77200088, АЖДХолбоо 70101177 утсаар тус тус хүлээн авдаг нь тогтооход бэрх, ослын дуудлагын үед санах боломжгүй олон оронтой дугаар байгаа зэрэг нь шуурхай алба дуудах боломжийг багасгаж байна.

2017 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Шуурхай албаны ажилтнуудтай хамтарч ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвд жолооны үнэмлэхний эрхээ сэргээхээр, тусгай зөвшөөрөл авахаар очсон, Да хүрээ захаар машин сонирхож буй, Авто тээврийн газарт улсын дугаар авахаар очсон жолооч нарыг сонгон даатгалд хамрагдалт болон шуурхай албаны үйлчилгээний хүртээмжийн талаар анкетын аргаар санал асуулга явуулж, үр дүнг боловсрууллаа.

Энэхүү судалгааны зорилго даатгалын компаниудын болон холбооны шуурхай албаны үйлчилгээний хүртээмжид дүгнэлт гаргаж цаашид авах арга хэмжээний талаар шуурхай албатай хамтарч санал боловсруулахад оршино.

Судалгаанд хамрагдсан нийт жолоочийн 88,7% нь жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулсан бөгөөд 57,3% нь даатгалын гэрээний дуусах хугацааг мэдэж байгаа нь жолооч нарын даатгалд өгөх ач холбогдол өндөр болсныг график №16-аар харуулж байна.



График №16



Нийт оролцогчийн 73.2% нь шуурхай албаар үйлчлүүлж байгаагүй бол 26,8% нь шуурхай алба дуудаж үйлчлүүлж байсан жолооч нар/график№17/ бөгөөд шуурхай албаны үйлчилгээнд дараах үнэлгээг өгсөн байна. /график №18/


График №17

График №18



Дээрх үнэлгээнээс шуурхай албаар үйлчлүүлсэн жолоочийг 100% гэж үзвэл:

График № 19



Шуурхай албаар үйлчлүүлж байсан судалгаанд хамрагдагсдын 62.5% нь удаан хүлээлгэсэн гэж хариулсан нь шуурхай албаны хүртээмж тааруу, ослын тохиолдолд хурдан шуурхай очиж үйлчилгээ үзүүлж чаддаггүй болох нь харагдаж байна. Мөн дуудсан боловч ирээгүй гэж хариулсан 12.5% байгаа нь шуурхай алба огт очоогүй гэх дүгнэлтээс илүү мөн л хурдан шуурхай очиж үйлчлээгүйгээс осол гарсны дараа замын хөдөлгөөнийг сааруулж, замын хөдөлгөөнд түгжрэл үүсч, иргэд бухимдаж замаа хурдан чөлөөлөх шаардлага тавьдгаас жолооч нар хөдлөөд явчихдаг байхыг үгүйсгэхгүй. Энэ даатгалын үйлчилгээг авч чадахгүйд хүрч байхыг үгүйсгэх аргагүй.

-Түүнчлэн зам тээврийн ослын газарт шуурхай алба очоогүйгээс нөхөн төлбөрөө авч чадаагүй тохиолдол байгаа юу? гэсэн асуултанд 93% нь байхгүй гэж хариулсан бөгөөд нээлттэй хэсэгт маш их удаан хүлээлгэсний эцэст нөхөн төлбөр гаргаж өгдөг гэж хариулсан, 5.6% -д нь шуурхай алба очоогүйгээс нөхөн төлбөрөө авч чадаагүй тохиолдол гарсан нь анхаарал татаж байна.

-Даатгалгүй болон даатгалын хугацаа дууссан үедээ зам тээврийн осол гаргавал хаана хандахаа мэдэх үү? гэсэн асуултад 90,1% мэдэхгүй, 9,9% мэднэ гэсэн боловч нээлттэй хэсэгт Замын цагдаад хандана гэж хариулсан нь мөн л анхаарал татаж байна.

-Зам тээврийн ослын үед хаана хандах вэ? гэсэн асуултанд Замын цагдаа ба даатгалын компанид гэж 45.1%, Зөвхөн Замын цагдаад гэж 29.6%, Зөвхөн даатгалын компанид гэж 21.1%, Энэ талаар ямар ч мэдээлэлгүй гэж 4.2% хариулсан нь “Эрүүл мэнд хохироогүй, хоорондоо мэтгэлцээн маргаангүй, согтууруулах ундаа хэрэглэсэн этгээд жолоодоогүй тохиолдолд даатгалын тохиолдол гэдгээр нь авч үзээд цагдаагийн байгууллагын тодорхойлолт шийдвэргүйгээр хохирлыг барагдуулна” гэсэн Санхүүгийн зохицуулах хорооноос шинээр гаргаж хэрэгжүүлж байгаа чиглэлийн тухай мэдээлэл төдийлөн хангалттай биш байна.

-Даатгуулсан компанийхаа шуурхай албаны утсыг мэдэх үү? гэсэн асуултанд 88.7% мэдэхгүй, 11.3 % мэднэ гэж хариулсан. Даатгалын компаниудын шуурхай албаны дуудлагын утсыг нэгдсэн нэг дугаарт оруулбал та дэмжих үү гэсэн асуултанд 85,9% дэмжиж байна гэсэн бол 12,7% шаардлагагүй гэж үзсэн. Цаашид шуурхай албыг нэгдсэн журмаар зохион байгуулах, иргэдэд тогтооход хялбар 3 оронтой нийтлэг дугаарт бүх шуурхай албаны утсыг холбох, холбогдсон тохиолдолд шуурхай албаны үйлчилгээг хэрхэн гүйцэтгэсэн, нөхөн төлбөр авсан эсэхэд хяналт тавих шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

АЖДХолбоо нь 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Удирдах зөвлөлийн хуралдаанаар “Албан журмын даатгагчдын холбооны шуурхай албаны үйл ажиллагаанд мөрдөх заавар”-ыг 29 дүгээр тогтоолоор батлуулж Жолоочийн даатгалын тухай хуулийн 25.3т зааснаар Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн боловч батлагдаагүйгээс шуурхай албаны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Даатгалын тохиолдлыг баталгаажуулах ажлыг аль болох хялбаршуулах шаардлага байгааг анхаарч үзэх нь зүйтэй.

2.4 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫГ БУУРУУЛАХ, АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ТАЛААР ОЛОН НИЙТЭД МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ОЛГОХОД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ НЬ ДААТГАЛД ХАМРАГДАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨШҮҮРЭГ БОЛЖ БАЙНА.

Албан журмын даатгагчдын холбооноос гишүүн даатгагчид, даатгуулагчдын ажлын уялдаа холбоог хангах, тэдний ашиг сонирхол, эрх ашгийг хамгаалж хийж байгаа нэг ажил нь нийтийг хамарсан системтэй тасралтгүй зохион байгуулах сурталчилгааны ажил юм.

Албан журмын даатгагчдын холбооны ажлын алба, түүний орон нутаг дахь салбарууд сургалт, сурталчилгааны нэгдсэн зохион байгуулалттай ажиллаж байна.

АЖДХ-ноос жолоочийн хариуцлагын даатгалын тухай 2012-2017 онд явуулсан сургалт, сурталчилгааны хүртээмж, үр дүнг хэмжихдээ даатгалын гэрээний тоо, хураамжийн орлого, даатгалын тохиолдлын тоо, нөхөн төлбөрийн түвшин зэрэг тоон үзүүлэлтийг ашиглан, сургалт, сурталчилгааны ажлын 6 жилийн тайлан мэдээнд судалгаа хийж дараах дүгнэлт хийсэн болно.

Сургалт, сурталчилгааны ажлыг АЖДХ-ны дүрмийн 2.2.13 -д зааснаар холбооны зорилгод нийцүүлэн холбооны үйл ажиллагааг /тус дүрмийн 2.2.1 - 2.2.12 заалт/ нийтэд таниулах, даатгалын тохиолдлыг бууруулах, албан журмын даатгалын сургалт, сурталчилгаа явуулах гэж заасан байна.

Холбооноос жил тутам гаргадаг үйл ажиллагааны тайланд сургалт, сурталчилгааны ажлыг тайлагнахдаа:

- ❖ **2012 онд** “Жолоочийн даатгалын хууль хэрэгжиж эхэлснийг нийтэд мэдээлэх, хуулийг хэрэгжүүлэх зорилго чиглэлд”
- ❖ **2013-2014 онд** “Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжүүлэх, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт сурталчилгааг даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх хөшүүрэг болгон ашиглах”

- ❖ **2015-2016 онд** “Жолоочийн даатгалын хуулийн хэрэгжилтийг хангах, зам тээврийн ослыг бууруулах, даатгагч, даатгалын төлөөлөгч, зуучлагч нарыг мэдээллээр хангах, тэднийг чадавхижуулах чиглэлээр”
- ❖ **2017 онд** “Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжүүлэх, зам тээврийн ослыг бууруулах, албан журмын даатгалын талаар олон нийтэд мэдлэг, мэдээлэл олгох чиглэлээр” тодорхой зорилт тавьж ажилласан юм.

2017 онд ажлын албанаас Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт болон жолоочийн хариуцлагын ач холбогдлыг олон нийтэд хүргэх, зам тээврийн ослыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн телевизийн реклам, шторк, зөвлөгөө болон мэдээ мэдээллийн нэвтрүүлгийг хамтран бэлтгэх, нэвтрүүлэх чиглэлээр “Дижитон” ХХК студитэй хамтран ажиллаж, ТВ9 телевизийн “Гарц” нэвтрүүлгээр 20 дугаар нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэсэн.

MNB,C1, NTV,Эх орон ТВ, ТВ9, UBS телевизүүдийн нэвтрүүлэгт 70 удаа, өдөр тутмын сонин хэвлэл, радио нэвтрүүлгээр 49 удаа, олон хандалттай вебсайтуудаар дамжуулан сошиал сурталчилгааг нийт 97 удаа, Хөдөлгөөнт сурталчилгаа нийт 100 удаа, “За рулём Монгол”, “Супер жолооч” сэтгүүлд нийт 183000 удаагийн давтамжтай нийтлэл, баннерийг хэвлүүлж гарын авлага, материал бэлтгэн орон нутагт хүргүүлж сургалт сурталчилгаанд өргөн ашиглаж байна.

Мөн, ажлын албанаас бэлтгэсэн Зам тээврийн ослоос сэргийлсэн агуулга бүхий санамж 1000 ширхэг, сэрэмжлүүлэг 2000 ширхэг хэвлүүлж орон нутгийн салбаруудаар дамжуулан олон нийтэд тараах зорилгоор орон нутаг дахь салбарыг материалаар хангаж орон нутгийн мэдээллийн хэрэгслийг ашиглаж хамтран ажиллахын зэрэгцээ даатгагчдын төлөөлөгч, иргэд, аж ахуйн нэгжүүдэд сургалт тасралтгүй зохион байгуулж байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт болон жолоочийн хариуцлагын ач холбогдлыг олон нийтэд хүргэх, зам тээврийн ослыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, даатгалын мэргэжлийн оролцогчдыг чадавхижуулах чиглэлээр “Хохирлын үнэлгээчний мэргэшил олгох анхан шатны сургалт”, “Даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалт”, “Даатгалын зуучлагчийн эрх олгох сургалт”, “Төв,орон нутгийн замын цагдаагийн ахлах байцаагч нарын сургалт”, “ЗЦА-ны Төв , орон нутгийн удирдах ажилтны сургалт зөвлөгөөн”, “МДХ-оос зохион байгуулсан Даатгалын шинэ ажилтнуудад мэргэшил олгох сургалт”, “Хаан банкны харилцагчдын өдөрлөг сургалт”, “Монголын аялал жуулчлалын холбооноос хөтөч, жолооч нарт зохион байгуулсан сургалт”, “Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлага болон инженер техникийн албан хаагчдад техникийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах” чиглэлээр Нийслэлийн авто тээврийн газраас зохион байгуулсан байна. 2017 онд Даатгалын мэргэжлийн оролцогчдыг чадавхижуулах 12 удаагийн сургалтаар нийт 808 иргэнд мэдлэг мэдээлэл олголоо.

Албан журмын даатгагчдын холбооноос 2017 онд Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зам тээврийн ослыг бууруулах, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхтэй холбогдуулж даатгуулагч, даатгалын төлөөлөгч, зуучлагч нарыг мэдээллээр хангах, тэднийг чадавхижуулахад чиглэгдсэн сургалт, сурталчилгааны ажилд нийт 63,7 сая төгрөг зарцуулсан байна.

Албан журмын даатгагчдын холбоо Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх, олон нийтийн даатгалын мэдлэг, мэдээллийг сайжруулах чиглэлийн сургалт, сурталчилгааны ажилд 2012

оноос хойш нийт 408,5 сая төгрөг зарцуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад 15 хэлбэрээр, 2012-2017 онд нийт 310.157 тоон давтамжтайгаар мэдээлэл түгээсэн байна.

Хүснэгт №21. Сургалт, сурталчилгааны /агуулга, хэлбэр, тоон үзүүлэлтээр/

д/д	Сургалт, сурталчилгааны хэлбэр	Тоо
1	Телевизийн цуврал нэвтрүүлэг, ярилцлага	155 удаагийн
2	“Монгол хүн Монголын баялаг” видео сэрэмжлүүлэг	7 удаагийн
3	“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” сэдэвт шторк	9 ш
4	Дэлгэцийн богино хэмжээний бүтээлийн уралдаан	1 удаа
5	Радио нэвтрүүлэг, FM	176 удаагийн
6	Сонинд, сэтгүүлд ярилцлага, нийтлэл	6 удаагийн
7	Хэвлэлийн бага хурал	1 удаа
8	Сургалт	45 удаагийн
9	Хэвлэмэл сурталчилгаа / тараах материал, брошур, анхааруулга, мэдээллийн самбар..гм/	301,646 удаагийн
10	TV Хэлэлцүүлэг	5 удаагийн
11	Өдөрлөг	3 удаагийн
12	Товхимол /гарын авлага/	1000ш
13	Телефоны бүх операторын хэрэглэгч даатгуулагчид гэрээгээ сунгахыг сануулсан SMS	1 удаагийн үйлдлээр 7100 хүнд
14	Смарт, Андроид, IOS системтэй гар утсанд зориулсан “Автодорцов-жолоочийн ухаалаг туслах” болон “Joloochiindaatgal” аппликейшн	2
15	Цуглаан	1 удаа
	Нийт давтамж	310,157

Хүснэгт №21-ээс харахад хамгийн их сонгож ашигласан мэдээллийн хэрэгсэл нь:

- Хэвлэмэл сурталчилгаа буюу 301.646 удаагийн давтамжтай
- Радио нэвтрүүлэг /FM/ 176 удаагийн,
- Телевизийн нэвтрүүлэг 155 удаагийн. Интернет /сошиал/, сонин сэтгүүлийн сурталчилгааг хамгийн бага ашигласан байна.

Хэвлэлийн хүрээлэнгээс 2016 онд явуулсан судалгаагаар хэрэглэгчийн хамгийн их мэдээлэл авдаг мэдээллийн хэрэгслээр:

- Телевиз 99% /энэ дотроо 55% нь телевиз үзэнгээ давхар FB, интернет, сонин сэтгүүл харж байдаг гэж хариулсан байна/
- Интернет /сошиал/ 51-61%
- Сонин сэтгүүл 42-51%
- Радио, fm 27%
- Гудамжны самбар болон хэвлэмэл сурталчилгаа 17 % эзэлж байна

Манай улсын хувьд телевиз өнөөг хүртэл чухал мэдээллийн хэрэгсэл байгааг харуулж байгаач интернет телевизийн байр суурийг булаах түвшинд ирсэнд анхаарал хандуулах нь зүйтэй байна.

Манай холбооны хамгийн их сонгож ашигласан суваг болох хэвлэмэл сурталчилгаа , радио нэвтрүүлэг / FM / нь хэвлэлийн хүрээлэнгийн судалгаатай харьцуулбал хамгийн бага хүртээмжтэй буюу хамгийн өндөр өгөөж нь 17-27 %-ийн үр дүнтэй харагдаж байгаад ч дүгнэлт хийж байна.

Мөн дараа нь TV нэвтрүүлэг сонгосон байгаа нь өндөр өгөөжтэй харагдаж байгаач Улаанбаатар хотын хэмжээнд албан ёсны зөвшөөрөлтэй 92 телевиз байдгаас 68 нь тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр телевизүүд нь хэрэглэгчийг хувааж үзэлтийг багасгах сөрөг талтай мөн маркетингийн бусад идэвхжүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн өндөр зардалтай тул сурталчилгааг үр дүнтэй хүргэх бусад аргыг хайх нь зүйтэй гэж үзэж байна.

Сургалт, сурталчилгааг даатгалын гэрээ, хураамжийн орлоготой харьцуулвал:

Хүснэгт № 22. Даатгалын гэрээ, хураамжийн өсөлтийн түвшин/оноор/

	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Даатгалын гэрээний тоо	10.9 % өссөн	16.1% өссөн	4.6 % өссөн	5.03 % өссөн	8,8% өссөн
Даатгалын хураамжийн орлого	6.6 % буурсан	21.3 % өссөн	13.7 % өссөн	15.7 % өссөн	8.2% өссөн

Хүснэгт №22-оос харахад хэдийгээр Жолоочийн хариуцлагын даатгал нь хуулийн зохицуулалт, албадлагын шинж чанартай, тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа зэрэг шалтгаануудаас урсгалаар өсдөг ч, нийгэмд шинэ тутамд хэрэгжиж буй хуулийн ач холбогдлыг сурталчлан таниулах, мэдээ мэдээлэл тасралтгүй түгэн цацагдсаны үр дүнд даатгалд хамрагдалтын хэмжээ тогтмол өсөлттэй буюу 2017 оноос 30 орчим хувь нэмэгдэж, энэ нь даатгалын компаниуд нийгмийн хэрэгцээг хангах хэмжээнд үйлчлэх эдийн засгийн нөөц чадавхыг бий болгоход нөлөөлсөн байна.

Нөгөө талаас зам тээврийн ослыг бууруулах сургалт сурталчилгааны дүнд жолоочийн хариуцлага сахилга сайжирч жил тутам төлж буй хураамжийн хэмжээ итгэлцүүрээр тодорхой хувиар буурч тооцогдох ёстой.

Эндээс дүгнэхэд “Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжүүлэх, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт сурталчилгааг даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх хөшүүрэг болгон ашиглав” гэсэн дүгнэлт батлагдаж даатгалын компаниудын ашгийг нэмэгдүүлэх чиглэлд түлхүү анхаарч, жолоочийн хариуцлага сахилгыг сайжруулах, ослын тохиолдлыг бууруулах талаар цаашид анхаарах шаардлага байна.

Сургалт, сурталчилгааг даатгалын тохиолдлын тоо, нөхөн төлбөрийн хэмжээтэй харьцуулбал:

Хүснэгт №23. Даатгалын тохиолдолын тоо, нөхөн төлбөрийн түвшин /он оноор/

	2013	2014	2015	2016	2017
Даатгалын тохиолдлын тоо	34.58%	36.96%	25.30%	1.3% буурсан	5,5% буурсан
Даатгалын нөхөн төлбөрийн дүн	21.50%	46.60%	21%	0,7 % буурсан	5,9% өссөн

Дээрх үзүүлэлтээс харвал 2013-2017 онд даатгалын гэрээ, хураамжийн орлого нэмэгдэхийн хирээр даатгалын тохиолдлын болон нөхөн төлбөрийн тоо өссөн үзүүлэлттэй байсан бол, 2015-2017 онуудад даатгалын гэрээ, хураамжийн орлого өссөн ч даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн тоо багахан хэмжээгээр буурсан үзүүлэлттэй байгаа нь сүүлийн 2 жилд түлхүү явуулсан зам тээврийн ослыг багасгах сургалт, сурталчилгаа нийгмийн тодорхой сегментэд чиглэгдэн хүрсэн байна.

Эцсийн дүнд сургалт, сурталчилгааны ажлыг гэрээ, хураамжийн орлого, даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн тоотой /хүснэгт №22, хүснэгт №23/ харьцуулсан үр дүн эерэг хандлагатай харагдаж байгаа нь Жолоочийн даатгал нь хуулийн зохицуулалттай албадлагын шинж чанартай, авто машины хэрэглээ хурдацтай өсөн нэмэгдэж буй, холбооны удирдлагын зүгээс хангалттай зардлын төсөв гаргасан, сургалт сурталчилгааг оновчтой, оновчгүй байдлаар тасралтгүй цацсан зэрэг хүчин зүйлсээс хамаарч байна. Гэвч сургалт, сурталчилгааны /хүснэгт №21/ бүтэц, агуулга, төлөвлөлт, явуулж буй арга барил, цаг үе, хүртээмжийн тооцоолол, мэдээллийн хэрэгслийн сонголтын хувьд хангалттай үнэлгээ харагдахгүй байна. Нийт даатгалын компаниудын сургалт, сурталчилгааны ажлыг нэгтгэн зохион байгуулахад анхаарал хандуулах шаардлага тулгарч байна. Цаашид нийт даатгагчид анхаарвал зохих зарим санааг дурдвал:

Сургалт сурталчилгааны өртөг өндөр, үр дүн бага, уламжлалт арга барилаас татгалзаж, цаг үеийн нөхцөл байдлаа мэдэрч, сурталчилгааны оновчтой арга хэрэгслийг тодорхойлж, шинэ санал санаачилга бий болгох. Манайд түгээмэл ашиглаж байгаа сурталчилгааны бүтээгдэхүүнүүдээс өөрөөр сэтгэж, бүтээлчээр хандаж чадвал, уламжлалт сурталчилгаа түгээх сувгаас илүү үр дүнтэй, бага зардалтай, урт хугацаанд үнэ цэнээ хадгалж чадна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

- Сурталчилгааны төлөвлөлт хийхдээ арга хэлбэрийг уламжлалт хэлбэрээс гажин цоо шинэ арга техникүүдийг ашиглах, бодлогоо сайжруулах, сурталчилгаагаа оновчтой байршуулах, үр нөлөөг нэмэгдүүлэхэд цаашид анхааран ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Онлайн контент, онлайн сурталчилгаа хамгийн үр дүнтэй гэж үзэх болсон өнөө цагт зардал бага, хүртээмж өндөр энэхүү аргыг түлхүү ашиглахыг анхаарах явдал юм.
- Маркетингийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтөө урьдчилан ашиглах нь зүйтэй.
- СУДАЛГАА,ХЯНАЛТ гэсэн үе шатуудыг ашиглах, энэхүү үе шатуудыг алгассанаар, өөрийн зардлын үр дүнг тооцохгүй байх, хэрэглэгчийг мэдрэхгүй байх, сувгуудын чанарыг үнэлэхгүй байх зэрэг олон сөрөг нөлөөтэй байна.
- Монголчуудын өргөн хэрэглээ болсон “Нүүр ном” –ын хаяг нээж залуусыг өдөөсөн шинэлэг санаануудыг гарган байршуулж, өдөр тутам хөтлөн явуулах. Жич: Жолоочийн хариуцлагын даатгал төлсөн эсэх, төлсөн итгэлцүүр, даатгалын тохиолдол гаргасан тоо, нөхөн төлбөрийн

хэв маягаар таныг хир хариуцлага, сахилгатай хүн бэ? гэдгийг сонжиж болно..., /Цаг агаарын урьдчилсан мэдээтэй уялдуулан анхны цас орохыг сануулж, өвлийн дугуйгаа солиорой/ ... гм..

- Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжүүлэх, зам гээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт сурталчилгааг даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх хөшүүрэг болгон ашиглаж байгаа нь логикийн хувьд буруу биш ч, энэ нь ажлын оновчтой чиглэл, дүгнэлт биш даатгуулагчийн хувьд сөрөг сэтгэгдэл төрөхөөр байна. Сургалт, сурталчилгааны үр дүнд гэрээ, даатгалын хураамжийн орлого өсөн нэмэгдэж, орлого өсөлтөө хэрхэн юунд зарцуулж байгаа, тус зарцуулалт нь эргээд нийгэмд, жолооч нарт ямар ач холбогдол, үр дагавар авч ирж байна вэ? гэдэг талаас нь мэдээлэл түгээж, дүгнэж ажиллавал нийгмээс эерэг хандлага авах болно.
- Даатгалын компани болон бусад холбогдох байгууллагатай хэлэлцэж Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний маягтын арын хоосон нүүрэнд гэрээ хийхдээ анхаарах зүйл, зам тээврийн осол буюу даатгалын тохиолдлын үед хаана хандах холбоо барих утас, даатгалын сангаас нөхөн төлбөр олгох тохиолдлууд, ямар тохиолдолд хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх вэ? зэрэг хэрэгтэй мэдээллүүдийг боловсролтой, боловсролгүй хэн ч ойлгох байдлаар байршуулах ..гм өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх санаанууд гаргаж ажиллах.
- Мэдээллийн сангаас жолоочийн даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн мэдээлэлд шалгалт хийсэн тайланд тулгуурлан, даатгалын компаниудын бүртгэлийн ажилтнуудад тодорхой давтамжтайгаар сургалт явуулах.
- Албан журмын даатгагчдын холбооны дүрмийн 2.2.13 Холбооны үйл ажиллагааг нийтэд таниулах, даатгалын тохиолдлыг бууруулах сургалт, сурталчилгаа явуулах гэсэн үндсэн зорилгыг орхигдуулахгүй холбогдох байгууллагуудтай хамтрах буюу олон улсын зах зээлд нэвтэрсэн албан журмын даатгалын бүтээгдэхүүн, зарчим хэм, хэмжээг судалж сургалтанд нэвтрүүлж ажиллавал эдийн засагт албан журмын даатгалын эзлэх хувийг нэмэгдүүлэх боломжтой юм. Мөн албан журмын даатгалын тухай мэдээлэл даатгагч, даатгуулагч нарт хүрэх ажилд шинэ арга технологи ашиглах болно.

ГУРАВ. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХОЛБООНЫ ДОТООД АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ.

3.1. 2017 оны санхүүгийн үр дүнгийн талаар

Холбооны жолоочийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн тайланг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль Төрийн бус байгууллагын хууль, холбогдох бусад хууль болон олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримтлан 2017 оны 1 дүгээр сарын 1 ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31 ний хооронд хийгдсэн бүхий л ажил гүйлгээг анхан шатны баримтад тулгуурлан бүртгэж тайлагнав.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйл, Сангийн сайд, Зам тээврийн сайдын хамтарсан 2013 оны 01 дүгээр сарын 23 ны өдрийн 20/19 дүгээр тушаалаар батлагдсан “Жолоочийн даатгалын санд хөрөнгө шилжүүлэх” журмын баримтлан жолоочийн даатгалын сангийн орлогыг төвлөрүүлж, жолоочийн даатгал тухай хуулийн 18 дугаар зүйлийг баримтлан сангаас нөхөн төлбөрийг олгож, 23 дугаар зүйлийг баримтлан сангаас зарцуулалт хийж ажиллаа.

Тайлант хугацаанд 2015, 2016 онд хуримтлагдсан төр, төсвийн байгууллагаас авах авлагыг барагдуулж нийт авлагын дүнг 2,037,874.2 мянган төгрөгөөр буюу 92.25% бууруулж ажиллав. Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг 36,96 хувиар буюу 3,692,596.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн ба сангийн үлдэгдлийн 92.4% нь мөнгөн хөрөнгөөр, 6.3% нь үндсэн хөрөнгөөр, 1.3% нь авлагаар байршиж байна.

АЖДХолбоо (ГҮТББ)-ны гишүүдийн татварт 15,000.0 мянган төгрөг төвлөрүүлж, 10,798.9 мянган төгрөгийг холбооны үйл ажиллагаанд зарцуулан өөрийн хөрөнгийг 4,199.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.2 Орон нутгийн салбарын үйл ажиллагаа, үр дүн

Орон нутаг дахь салбарууд нь Холбооны үйл ажиллагааны чиг үүрэг болон Жолоочийн даатгалын тухай хуулийн ач холбогдлыг сурталчлах, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, хяналт шалгалтыг орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагатай хамтран орон нутгийн даатгуулагч иргэдийн дунд тогтмол зохион байгуулж ажилласан байна.

Хуулийн ач холбогдлыг орон нутгийн иргэдэд сурталчлахад орон нутгийн Засаг даргын тамгын газар болон Замын цагдаагийн тасаг, Авто тээврийн газартай хамтран ажиллаж байгаа нь салбараас зохион байгуулсан үйл ажиллагаанд зохих дэмжлэг болж байгаа нь сайшаалтай байна. Тухайлбал, Баян-Өлгий, Сэлэнгэ, Архангай, Завхан, Дорноговь, Орхон, Өмнөговь, Увс аймгууд нь хамтын ажиллагааны гэрээ, удирдамж зэргийг боловсруулан батлуулж ажиллажээ.

Салбарууд тухайн орон нутагт гишүүн даатгалын компаний салбаруудтай хамтран ажиллах, тэдний үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, цаг үеийн болон тулгамдаж буй асуудлаар ярилцах, хамтарсан уулзалтыг тогтмол хийж ажилласан нь үр дүнгээ өгсөн байна. Баян-Өлгий, Архангай, Увс, Төв аймаг дахь салбарууд даатгалын компанийн салбаруудын менежер, захирлуудтай уулзалт хийж санал солилцож сургалт хийсэн нь даатгалд хамрагдалтыг эрс сайжруулж чадсан жишээг олон аймаг дээр дурдаж болно.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.4 дэх заалтын дагуу 21 аймаг АТБӨЯХАТ-ын 10 хувийг батлагдсан хуваарийн дагуу даатгалын санд төвлөрүүлэх ажилд Холбооны орон нутаг дахь бүх салбарууд нэлээд анхаарч ажилласан. 2017 онд 21 аймгаас нийт 849,788,02 төгрөг төвлөрөхөөс 1128826,1 төгрөг хуваарийн дагуу төвлөрсөн бөгөөд Өмнөговь, Орхон, Хөвсгөл, Ховд аймгууд 2016 оны гүйцэтгэлийн зөрүүг нэмж төвлөрүүлсэн байна.

Тайлангаас харахад салбарууд аймгийнхаа ЗЦТ-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтын удирдамж боловсруулан батлуулж сар, улирал тутам хяналт шалгалт хийж хэвшсэн байна. Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2017 онд нийт 117 удаа хяналт шалгалтын ажил зохион байгуулж 28640 тээврийн хэрэгслийг хамруулан шалгахад 2152 тээврийн хэрэгслийн жолооч Жолоочийн даатгалын тухай хууль зөрчсөн байсныг илрүүлж арга хэмжээ авчээ. Орон нутгийн салбарын ажилтан, менежерүүд жолоочийн даатгалын тухай хуулийг зөрчсөн эдгээр жолоочийн зөрчлийг газар дээр нь арилгуулснаар замын хөдөлгөөнд оролцуулсан байна. 2014, 2015, 2016 онуудын салбарын үйл ажиллагааны тоон үзүүлэлтүүдийг харьцуулбал:

№	Үйл ажиллагаа	2014	2015	2016	2017
1	Шалгалтад хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо	16675	56009	26300	28640
2	Илрүүлсэн зөрчлийн тоо	3796	13898	2758	2152
3	ЖДТХуулийн 28.1.1-н дагуу хариуцлага хүлээлгэсэн жолоочийн тоо	1452	122	2*	
4	Даатгалын тохиолдлын дуудлагын тоо	828	461	643	68

* 2016 оны 4 дүгээр сараас ЖДТХуулийн 28.1.1-н дагуу хариуцлага хүлээлгэхгүй болсон.

2015 онд ЗЦТ-тай хамтран зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хийсэн хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн зөрчлийн тоо /13898/ хамрагдсан тээврийн хэрэгслийн тоотой /56009/ харьцуулахад 24,8 хувь байсан бол 2016 онд 10,4 хувьтай болсон нь Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт сайжирсаныг харуулж байна.

Хууль зөрчсөн жолоочийн ихэнх нь даатгалын гэрээнд нэр бичигдээгүй тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцох, тээврийн хэрэгслийн өмчлөлийн нэр солигдох үед даатгалын гэрээ хүчингүй болно гэдгийг ойлгоогүй зэрэг зөрчлүүд байхаас гадна бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй, бичиг баримтгүй хөдөлгөөнд оролцох зэрэг дутагдлууд байна.

Мөн зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн ажлын хүрээнд орон нутгийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудад сургалт хийж жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах талаар салбарууд харилцан адилгүй ажилласан байна. Тайлант хугацаанд, салбарууд нийт 215 удаагийн сургалт хийж 8257 иргэдийг хамруулж жолоочийн даатгалын ач холбогдлыг сурталчилсан сургалт хийж, иргэдийн асуултанд хариулах, даатгалын гэрээг хийхдээ юуг анхаарах талаар зөвлөгөө өгч Архангай аймагт Тамир ТВ, Баян-Өлгий аймагт MNB-2 телевизээр, Увс аймагт МВС Увс телевизээр, Сүхбаатар аймагт ВВН телевизээр тус тус сурталчилсан байна. Ялангуяа Баян-Өлгий, Булган, Архангай, Дорноговь, Орхон, Төв, Хөвсгөл аймгууд илүү олон хүн хамруулж жигд сайн ажилласан байна.

Мөн салбарууд төрийн болон төрийн бус байгууллага, хамтран ажилладаг байгууллага, иргэдтэй 8 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж 618 хүн, 45 удаагийн уулзалтаар 3943 иргэдийг хамруулжээ.

Холбооны үйл ажиллагаа болон Жолоочийн даатгалын тухай хуулийн ач холбогдлыг хулдаасан самбар, тарааж өгөх материал, цахим сүлжээ, орон нутгийн ТВ, ФМ, Лед дэлгэцээр дамжуулан сурталчилж хэвшсэн байна. Бүх салбар нь өөрийн фэйсбүүк хаяг нээж Жолоочийн даатгалын тухай хуулийн ач холбогдлыг цахим сүлжээгээр сурталчилж ажилласан нь үр дүнгээ өгч байна.

Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолын дагуу тус Холбооны орон нутаг дахь салбарууд бүсчилсэн зохион байгуулалтад орж 8 салбар болон зохион байгуулагдсан. Үүнтэй холбогдуулан Холбооны Гүйцэтгэх захирлын 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 02/53 тоот тушаалаар “Салбарын ажиллах журам”-ыг шинэчлэн батлан мөрдөж эхэлсэн бөгөөд Холбооны орон нутаг дахь салбар нь Жолоочийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомж, Албан журмын даатгагчдын холбооны дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй бүтцийн нэгж хэвээр ажиллана. Хууль тогтоомжид заасан чиг үүргийг ханган биелүүлэх ялангуяа зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын

хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад олон нийтийн мэдлэг, соёл,ухамсрыг дээшлүүлэх ажлыг даатгалын компаниудын орон нутаг дахь салбар, даатгалын мэргэжлийн оролцогчид болон орон нутгийн замын цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллана.

3.3 Дотоод хяналт, салбар, нэгжийн ажил дүгнэсэн тухай

Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагаа нь Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Албан журмын даатгагчдын холбооны дүрэм болон бусад холбогдох хууль эрхзүйн актад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, шалтгаан нөхцөлийг тодруулан уг зөрчлийг дахин гаргуулахгүй байх, Холбоо хуулиар хүлээсэн үүргийнхээ хэрэгжилтийг хангуулахад холбогдох арга хэмжээ авах зорилго тавьж ажиллалаа.

Холбооны хэвийн үйл ажиллагааг ханган Удирдах зөвлөлийн тогтоолуудыг хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ Холбоо гишүүдийнхээ уялдаа холбоог хангах үүргийнхээ хүрээнд 2017 оны 4 дүгээр сард Холбооны удирдах зөвлөл, СЗХорооны 6 ажилтан, гишүүн Даатгалын компаниудын удирдах ажилтан, төлөөлөгчид, зуучлагчид, Авто СОС ХХК-ны ажилтан, Холбооны орон нутгийн менежер, ажилтнууд, ТВ, радиогийн сурвалжлагч, сэтгүүлчдийг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж Холбооны өмнөх оны тайлан болон шинээр боловсруулсан Шуурхай албаны ажиллах журам, Мэдээллийн сангийн МИИС системийг ашиглах гэрээний төслийг танилцуулж хэлэлцүүлэн тулгамдаж буй асуудал цаашид авах арга хэмжээний талаар ярилцаж уулзалт хэлэлцүүлгээс гарсан саналуудыг журмуудад тусгаж шийдвэрлэсэн.

Дотоод хяналтын ажилтны хувьд, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааны мэдлэг дутмагаас тус салбарын үйл ажиллагааг хянах боломжгүй байлаа. Холбооны зүгээс энэ байдалд анхаарч Бизкон ХХКиас эрхлэн явуулдаг Дотоод хяналт, аудитын сургалтанд Холбооны 5 ажилтныг хамруулсан.

Жолоочийн хариуцлагын даатгалыг хэрэгжүүлэхэд даатгагч, зуучлагч, төлөөлөгч 3000 гаруй хүн оролцож байгаа бөгөөд энэ хүмүүсийн дотор сайн ажиллаж байгаа байгууллага, хүмүүсийг АЖДХолбооноос шагнаж урамшуулах хүсэлтүүд ирсэнтэй холбогдуулан "АЖДХолбооны нэрэмжит шагналын журам"-ын дагуу "АЖДХолбооны Өргөмжлөл" шагналаар даатгагчдын тодорхойлолтыг үндэслэн 2017 онд 13 хүн шагнасан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Холбооны 2017 оны үйл ажиллагааг сүүлийн 4 жилийн статистиктай зэрэгцүүлж үзээд дараах дүгнэлт өгч тодорхой санал дэвшүүлж байна.

АЖДХолбооны 2017 оны үйл ажиллагааг нэгтгэн дүгнэвэл цомхон орон тоо, бүтцээр, бага зардлаар ажиллаж, төвлөрүүлбэл зохих орлогын төлөвлөгөөг 16 хувиар буюу 703,2 сая төгрөгөөр давуулж, төсөвт зардлыг 21.5 хувиар буюу 373,3 сая төгрөгөөр хэмнэж ажилласны зэрэгцээ

мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, эрхзүйн орчныг сайжруулахад бодитой арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажилласан байна. 2015 оноос хойш үүссэн авлагын хэмжээг 2037,8 сая төгрөгөөр бууруулж, төвлөрүүлбэл зохих орлогыг бүрэн төвлөрүүлсний үр дүнд харилцах, хадгаламжаар Даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг 5,6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж хуулиар хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн хангаж ажиллажээ. Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааг идэвхитэй явуулснаар жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалт жил дараалан өсч хураамжийн хэмжээ ч нэмэгдсэн нь даатгагч, зуучлагчидтай сайн хамтран ажилласан энэ хамт олны зөв зохион байгуулалт, уйгагүй хөдөлмөрийн үр дүн гэж дүгнэж байна. 2017 онд хэрэгжүүлж эхэлсэн нэг шинэлэг ажил бол дотоод хяналтыг сайжруулж мэдээллийн чанарт болон шуурхай алба, сургалт сурталчилгааны ажилд судалгаа хийж цаашид анхаарвал зохих чиглэлийг тодорхойлох болсон явдал мөн. Ийм ололт амжилт байгаа боловч цаашид Жолоочийн хариуцлагын даатгалыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах санал дэвшүүлж байна.

1. Хариуцлагын даатгалтай холбогдол бүхий хууль тогтоомж, эрхийн актыг системчлэн кодификац хийхийн зэрэгцээ Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шинэчлэн найруулах, дагаж гаргах эрхийн актын төслийн хамт яаралтай боловсруулах.
2. Холбооны Засаглалын зарчмыг анхаарч төлөөллийн зарчмаар сонгогдох хуулийн заалтыг зөрчиж шууд томилж байгаа нь төлөөлөх чиглэлээр ажилд хандах хандлагыг алдагдуулах, орхигдоход хүргэж байгааг анхаарч цаашид зөв чиглэл тогтоож мөрдүүлэх. Холбооны удирдах зөвлөлийн баталсан холбооны дүрэм, хяналтын зөвлөлийн журмыг хэрэгжүүлэх ажлыг сайтар зохион байгуулах боломж бүрдүүлэх.
3. Холбооны зүгээс даатгагч, зуучлагч нарын үйл ажиллагааг уялдуулах, МИИС-т нийлүүлэх мэдээллийн чанарт тавих хяналтыг сайжруулах шаардлага бий болсоор байна. Даатгагч зуучлагчдыг жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагааны талаар мэргэшүүлэх, сургалтанд заавал хамрагдсан байх тогтолцоог бий болгож хэвшүүлэх. Даатгагч, зуучлагч, даатгуулагчдад зориулсан сургалтын онлайн систем боловсруулж, нэвтрүүлэх.
4. Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдаж хураамж төлсөн өмчийн эзэн өөрөөс үл хамаарч даатгалын тохиолдолд өртсөн, хохирсон бол нөхөн төлбөр авдаг байх зарчмыг баримталж журамлах. Тухайлбал Жолоочийн даатгалын тухай хуулийн 5.1;19.10 дахь заалтыг уялдуулах г.м олон асуудал шийдэл хүлээж байгааг хууль, журмын шинэчлэл өөрчлөлтөөр дагах арга хэмжээ авах.
5. Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах ажилд ахиц гаргахын зэрэгцээ тэдний нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг улам чангатгах,ухамсар харилцааны соёлын түвшинг дээшлүүлэхэд холбооны үйл ажиллагааг чиглүүлэх
6. Жолоочийн хариуцлагын даатгал хэрэгжиж эхэлснээс хойш 6 жил боллоо. Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль түүнийг дагаж гарсан журам зааварт шуурхай алба, нөхөн төлбөр, мэдээллийн сантай холбоотой үйл ажиллагааг зохицуулж байгаа боловч үүнийгээ зөвхөн АЖДХолбооны үйл ажиллагаанд хамааруулж үндсэн том хэсгийг орхигдуулж энэ даатгалыг эрхлэх зөвшөөрөл олгосон Даатгалын компаниудад мөрдөх нэгдсэн журамгүй байгаа нь жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдлыг бууруулахад хүргэж байна. Даатгалын компаниудын нөхөн төлбөр олгох үндэслэл болгодог хохирол үнэлгээг хийх нэгдсэн аргачлал, зохицуулалтгүйгээр нийт хураамжийн 50 гаруй хувийг жил бүр зарцуулж байгаа явдалд дүгнэлт хийх шаардлага байна гэж үзэж байна. Албан журмын хариуцлагын даатгал эрхэлж буй

байгууллагуудад мөрдөх нэгдсэн чиглэлийн журам батлах эрхзүйн үндэслэлгүй гэсэн тайлбараар холбооны санал санаачилгыг хаасаар ирсэн нь ямар ч хяналтын тогтолцоогүй дур зоргоороо авирлах боломжийг бүрдүүлж өгч байна. Энэ нь жолоочийн даатгалыг хэрэгжүүлж буй одоогийн тогтолцоо буруу байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

7. Жолоочийн хариуцлагын даатгалыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхэд Зам тээврийн ослын улмаас үүссэн хохирлыг үнэн зөв тогтоохоос эхлээд нөхөн төлбөрийг (ЖХД-19.10) хэнд олгох, тээврийн хэрэгсэлд ямар зорилгоор оношилгоо хийх, оношилгооны дүгнэлтийг яаж хэрэгжүүлэх, засварын чанарт хэн хяналт тавих вэ? Энэ бүхнийг даатгуулагч даатгагчийг холбох механизм, үйлчилгээний төв цэг болгож ашиглах хүртэл анхаарч, шийдвэрлэх асуудал их байгааг эрх бүхий байгууллага нь судалж шийдвэрлэх нь зүйтэй.
8. Албан журмын даатгагчдын холбоог улсын бүртгэлд ГҮТББ гэж бүртгэсэн байгаа. Дүрэмд ч даатгалын тухай, жолоочийн даатгалын тухай хуульд зааснаас бусад үйл ажиллагааг төрийн бус байгууллагын тухай хуулийг баримталж ажиллахаар заасан байх боловч төрийн байгууллагын нэг агентлаг, албатай адил түвшинд ажиллаж байгааг анхаарч аль нэг талд нь шийдвэрлэх нь чухал байна. Албан журмын даатгалын хамрах хүрээ, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээ, нэр төрөл нэмэгдэж байгаатай холбогдуулан даатгалын тогтолцоонд зарчмын өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ өөрчлөлтийг хийхийн тулд Холбооны эрх зүйн байдлыг зөв тодорхойлох нь чухал байна. Бидний хувьд Холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд албан журмын даатгалын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцаж, даатгагч, даатгуулагч, хохирогчдод сэтгэл ханамжийн баталгаат бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлж даатгалын таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдэнэ гэж үзэж байгааг анхаарч үзэхийг хүсч байна.
9. Жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх гэрээний үүргийг хангуулахад эрх зүйн чадамжийг сайжруулах, гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдийн талаарх мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх. Орон нутаг дахь салбаруудыг бүсчилсэн зохион байгуулалтад оруулсантай холбогдуулан салбарын менежерүүдийг амь нас, гэнэтийн ослын даатгалд даатгуулах асуудлыг судалж хөрөнгийг төсөвт тусгаж шийдвэрлүүлэх.
10. Холбооны ажилтнуудыг мэргэшүүлэх, дадлагажуулах олон улсын адил үйл ажиллагаатай байгууллага хоорондын харилцааг идэвхжүүлэх, сургалт, судалгааны төв болгон хөгжүүлэхэд анхаарал хандуулахыг хүсч байна.

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО